

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ



ᠳᠡᠭᠡᠳ ᠰᠢᠭᠦᠬᠡ

МОНГОЛ УЛСЫН
ДЭЭД ШҮҮХ

2023 ТАЙЛАН

Улаанбаатар хот

ТАЙЛАНГИЙН АГУУЛГА


1. ХЯНАЛТЫН ЖУРМААР ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА.....	3
1.1. ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАНХИМ.....	4
1.2. ИРГЭНИЙ ХЭРГИЙН ТАНХИМ.....	5
1.3. ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ТАНХИМ.....	7
2. ШҮҮН ТАСЛАХ АЖИЛЛАГААНААС БУСАД АЖИЛ.....	9
2.1. ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАНХИМ.....	9
2.2. ИРГЭНИЙ ХЭРГИЙН ТАНХИМ.....	18
2.3. ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ТАНХИМ.....	22
3. ЕРӨНХИЙ ШҮҮГЧИЙН АЖЛЫН АЛБА.....	29
4. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР.....	31
4.1. ЗАХИРГАА, ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГА.....	31
4.2. ХЭРГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ УДИРДЛАГА.....	41
4.3. ШҮҮХИЙН ПРАКТИК СУДЛАЛ.....	42
4.4. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ АЖИЛ.....	46
4.5. ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА.....	49
4.6. САНХҮҮ, НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ.....	51
4.7. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ.....	52
4.8. ДОТООД АУДИТ.....	54

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН 2023 ОНЫ ТАЙЛАН


1.ХЯНАЛТЫН ЖУРМААР ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

Монгол Улсын дээд шүүх хуулиар олгосон чиг үүргийн хүрээнд хяналтын журмаар гаргасан гомдлуудыг хүлээн авч хянан шийдвэрлэх ажиллагаа явуулав.

Монгол Улсын дээд шүүхэд хүлээн авсан нийт 2884 хэрэг



Монгол Улсын дээд шүүхэд 2023 онд хүлээж авсан хэргийг 2022 онтой харьцуулсан үзүүлэлт



Монгол Улсын дээд шүүхийн хянан шийдвэрлэсэн хэргийг Танхим тус бүрээр авч үзвэл:


1.1.ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАНХИМ

Тайлант хугацаанд эрүүгийн хэргийн танхим **892** (хяналтын шатны журмаар **871**, шинээр илэрсэн нөхцөл байдалд тооцуулахаар **21**), өмнөх оны үлдэгдэл **10** хэрэг нийт **902** хэрэг хүлээн авснаас:

Танхимын нийт шүүгчийн хуралдаанаар **726** хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээс татгалзаж, **164** хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэж, **6** хэргийг гомдол, эсэргүүцлээсээ татгалзсан тул хэлэлцүүлэхгүй буцааж, одоо хуваарилагдсан нийт **6** хэргийн үлдэгдэлтэй байна.

Тайлангийн хугацаанд Эрүүгийн хэргийн танхимын нийт шүүгчийн хуралдаанаар **871** хэргийн гомдол болон холбогдох шүүхийн шийдвэрүүдийг хэлэлцсэнээс **726** хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээс татгалзаж, **145** хэргийг (үүнд шинээр илэрсэн нөхцөл байдалд тооцуулахаар ирсэн 21 хэрэг болон өмнөх оны үлдэгдэл 10 хэрэг ороогүй) хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн байна.

График 1



Хяналтын журмаар шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэгдсэн **164** хэргийн 15.9 хувь буюу **26** хэргийн тогтоол, магадлалыг хэвээр үлдээж, гомдол, эсэргүүцлийг хэрэгсэхгүй болгож, 28.6 хувь буюу **47** хэргийн тогтоол, магадлалд өөрчлөлт оруулж, 48.8 хувь буюу **80** хэргийн тогтоол, магадлалыг хүчингүй болгож, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэргийг хянуулах прокурорын дүгнэлтийн 1.8 хувь **3** дүгнэлтийг хүлээн авч, 4.9 хувь **8** дүгнэлтийг хэрэгсэхгүй болгосон байна.

Өөрчлөлт оруулсан **47** хэргийн 59.5 хувь буюу **28** хэргийг Эрүүгийн хууль буруу тайлбарлан хэрэглэсэн, 25.6 хувь буюу **12** хэргийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн үндэслэлээр өөрчлөлт тус тус оруулж, 14.9 хувь буюу **7** хэргийн зүйлчлэл өөрчлөлгүйгээр ялыг хөнгөрүүлжээ.

Хүчингүй болгосон **80** хэргийн 22.5 хувь буюу **18** хэргийн шийтгэх, цагаатгах тогтоол, магадлалыг хүчингүй болгож, 15 хувь буюу **12** хэргийн тогтоол, магадлалыг хүчингүй болгож, 62.5 хувь буюу **50** хэргийг бусад үндэслэлээр хүчингүй болгожээ.

Улсын ерөнхий прокурорын газраас прокурорын дүгнэлт бичиж ирүүлсэн нийт **8** цагаатгалын хэрэг хүлээн авч, үүнээс 27 хэлмэгдэгчид холбогдох **8** хэргийг хэрэгсэхгүй болгон цагаатгасан байна.

Хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн **164** хэргийн 45.1 хувь буюу **74** хэргийг шүүгдэгч болон тэдгээрийн өмгөөлөгч, 8.6 хувь буюу **14** хэргийг хохирогч болон тэдгээрийн өмгөөлөгч, 1.2 хувь буюу **2** хэргийг иргэний хариуцагчийн, 1.8 хувь буюу **3** хэргийг иргэний нэхэмжлэгчийн, 31.7 хувь буюу **52** хэргийг прокурорын эсэргүүцлээр, 11.6 хувь буюу **19** хэргийг прокурорын дүгнэлтээр хэлэлцжээ.

Хяналтын шатын эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн **164** хэргийг зүйлчлэлээр авч үзвэл:

Эрүүгийн хуулийн Аравдугаар бүлгээр **19**, Арван нэгдүгээр бүлгээр **15**, Арван хоёрдугаар бүлгээр **31**, Арван гуравдугаар бүлгээр **3**, Арван долоодугаар бүлгээр **44**, Арван наймдугаар бүлгээр **1**, Арван есдүгээр бүлгээр **2**, Хорьдугаар бүлгээр **1**, Хорин нэгдүгээр бүлгээр **1**, Хорин хоёрдугаар бүлгээр **13**, Хорин гуравдугаар бүлгээр **7**, Хорин дөрөвдүгээр бүлгээр **8**, Хорин долоодугаар бүлгээр **10**, Хорин наймдугаар бүлгээр **1**, цагаатгалын **8** хэргийг хянан шийдвэрлэсэн байна.


1.2. ИРГЭНИЙ ХЭРГИЙН ТАНХИМ

Тайлант хугацаанд иргэний хэргийн танхим 1460 (хяналтын шатны журмаар **1413**, харьяалал тогтоолгохоор **26**, шинээр илэрсэн нөхцөл байдалд тооцуулахаар **21**), өмнөх оны үлдэгдэл **16** хэрэг, нийт **1476** хэрэг хүлээн авснаас:

Танхимын нийт шүүгчийн хуралдаанаар **1468** хэргийг хянан шийдвэрлэж, үүнээс танхимын нийт шүүгчийн хуралдаанаар **1175** хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээс татгалзаж, **2** хэргийг танхимын нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцэхгүй буцааж, **244** хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэж, **2** хэргийг гомдол гаргаагүйд тооцож, **20** хэргийн шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянуулах хүсэлтийг хэлэлцэж, **25** хэрэгт шүүхийн харьяаллыг тогтоож, одоо хуваарилагдсан нийт **8** /хяналтын журмаар хүлээн авсан 6, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянуулах тухай хүсэлт 1, шүүхийн харьяалал тогтоолгох 1/ хэргийн үлдэгдэлтэй байна.

Тайлангийн хугацаанд Иргэний хэргийн танхимын нийт шүүгчийн хуралдаан **40** өдөр хуралдаж, нийт **1413** хэрэг хэлэлцсэнээс **235** хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээр, **1175** хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээс татгалзаж, **1** хэрэг хяналтын журмаар гаргасан гомдлоосоо татгалзаж, **2** хэргийг танхимын нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцэхгүй буцааж шийдвэрлэсэн байна.

Нийт хүлээн авсан 1476 хэргээс



Хяналтын журмаар хянан шийдвэрлэсэн иргэний **244** хэргийн **22.5** хувь буюу **55** хэргийн шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхиж, **23.8** хувь буюу **58** хэргийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, дахин хэлэлцүүлэхээр буцааж, **24.6** хувь буюу **60** хэргийн шийдвэр, магадлалд нэмэлт, өөрчлөлт оруулж, **22.5** хувь буюу **55** хэргийн магадлалыг бүхэлд нь буюу зарим хэсгийг хүчингүй болгож, шийдвэрийг хэвээр үлдээх буюу өөрчилж, **6.6** хувь буюу **16** хэргийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг буюу нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон байна.

Өөрчлөлт оруулсан **60** хэргийн **78,4** хувь буюу **47** нь хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, хэрэглэх ёсгүй хууль хэрэглэсэн, хууль буруу тайлбарлаж хэрэглэсэн, **21,6** хувь буюу **13** нь шүүх хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчсөн үндэслэлээр шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулжээ.

Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан **58** хэргийн **93.2** хувь буюу **54** хэргийг шүүх өөр хуулийг, эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн ба шийдвэрийг өөрчлөх боломжгүй гэж, **3,4** хувь буюу **2** хэргийг шүүх хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчсөн, **3,4** хувь буюу **2** хэргийг нотлох баримтыг шүүх дутуу бүрдүүлсэн үндэслэлээр шийдвэр, магадлалыг тус тус хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаажээ.

Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, нэхэмжлэлийг буюу хэргийг хэрэгсэхгүй болгосон **16** хэргийн **6.3** хувь буюу **1** нь зохигчийн эвлэрлийг баталсан, **93.7** хувь буюу **15** нь шүүх өөр хуулийг, эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн байна.

Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянуулах тухай хүсэлттэй **20** хэргийг тайлангийн хугацаанд шийдвэрлэсэн бөгөөд **18** хэргийн хүсэлтийг хангаагүй, **2** хэргийг хүсэлтээсээ татгалзсан үндэслэлээр хүсэлт гаргаагүйд тооцож шийдвэрлэсэн байна.

Хяналтын журмаар шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн хэргийн **48.3** хувь буюу **118** нэхэмжлэгчийн, **46.7** хувь буюу **114** хариуцагчийн, **5** хувь буюу **12** зохигчийн гомдлоор хянан хэлэлцэгджээ.

Хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн **244** хэргийг эрх зүйн төрлөөр авч үзвэл:


Иргэний хуулиар **203**, Хөдөлмөрийн тухай хуулиар **27**, Гэр бүлийн тухай хуулиар **3**, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар **7**, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар **1**, бусад хуулиар **3** хэргийг хянан шийдвэрлэжээ.

1.3.ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ТАНХИМ

Тайлант хугацаанд 523 (давж заалдах журмаар **25**, шинээр илэрсэн нөхцөл байдалд тооцуулахаар **6**, нэмж хяналтын шатны журмаар **492**), өмнөх оны үлдэгдэл **3** хэрэг нийт **526** хэрэг хүлээн авч,

Танхимын нийт шүүгчийн хуралдаанаар **396** хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээс татгалзаж, **100** хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэж, **4** хэргийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянуулах хүсэлтийг хэлэлцэж, **3** хэргийг нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсаныг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгож, **5** хэргийг танхимын нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцэхгүй буцааж, **3** хэргийг хяналтын журмаар гаргасан гомдлоосоо татгалзаж, гомдол гаргаагүйд тооцож, одоо хуваарилагдсан нийт **15** (хяналтын журмаар хүлээн авсан **9**, давж заалдах журмаар хүлээн авсан **4**, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянуулах тухай хүсэлт **2**) хэргийн үлдэгдэлтэй байна.

Тайлангийн хугацаанд Захиргааны хэргийн танхимын нийт шүүгчийн хуралдаан **39** өдөр хуралдаж, нийт **492** хэрэг хэлэлцсэнээс **89** хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээр, **396** хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээс татгалзаж, **2** хэргийг нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсаныг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгож, **2** хэргийг танхимын нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцэхгүй буцааж, **3** хэргийг хяналтын журмаар гаргасан гомдлоосоо татгалзаж, гомдол гаргаагүйд тооцож шийдвэрлэсэн байна.



Хяналтын журмаар хянан шийдвэрлэсэн захиргааны **100** хэргийн **23** хувь буюу **23** хэргийн шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхиж, **16** хувь буюу **16** хэргийн шийдвэр, магадлалд нэмэлт, өөрчлөлт оруулж, **29** хувь буюу **29** хэргийн магадлалыг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг хүчингүй болгож, шийдвэрийг хэвээр үлдээх, эсхүл өөрчилсөн, **5** хувь буюу **5** хэргийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, нэхэмжлэлийг хангасан, **11** хувь буюу **11** хэргийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон, **1** хувь буюу **1** хэргийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, хэргийг хэрэгсэхгүй болгосон, **3** хувь буюу **3** хэргийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцаасан, **12** хувь буюу **12** хэргийн магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр давж заалдах шатны шүүхэд буцааж шийдвэрлэсэн байна.

Өөрчлөлт оруулсан **16** хэргийн **87.5** хувь буюу **14** нь хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, хэрэглэх ёсгүй хууль хэрэглэсэн, хууль буруу тайлбарлаж хэрэглэсэн, **12.5** хувь буюу **2** нь шүүх хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчсөн үндэслэлээр шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулжээ.

Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан **15** хэргийн **53.3** хувь буюу **8** хэргийг шүүх хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчсөн, **46.7** хувь буюу **7** хэргийг хэрэглэх ёсгүй хууль хэрэглэсэн, хууль буруу тайлбарлаж хэрэглэсэн үндэслэлээр шийдвэр, магадлалыг тус тус хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаажээ.

Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, нэхэмжлэлийг буюу хэргийг хэрэгсэхгүй болгосон **11** хэргийн **27.2** хувь буюу **3** нь нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсаныг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгосон, **72.7** хувь буюу **8** нь шүүх өөр хуулийг, эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн байна.

Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянуулах тухай хүсэлттэй **4** хэргийг тайлангийн хугацаанд шийдвэрлэсэн бөгөөд хүсэлтийг хангасан **1**, хангаагүй **3** байна.

Хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн **100** хэргийн **36** хувь буюу **36** итгэмжлэгдсэн төлөөлөгчийн, **13** хувь буюу **13** нэхэмжлэгчийн, **18** хувь буюу **18** өмгөөлөгчийн, **17** хувь буюу **17** хариуцагчийн, **16** хувь буюу **16** гуравдагч этгээдийн гомдлоор хянан хэлэлцжээ.

Хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн **100** хэргийг эрх зүйн төрлөөр авч үзвэл: газрын маргаан **19**, ашигт малтмалын маргаан **4**, төрийн албаны маргаан **8**, татварын маргаан **14**, эд хөрөнгийн эрхийн бүртгэлтэй холбоотой маргаан **4**, шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах, хэрэглэгчийн эрх ашигтай холбоотой маргаан **11**, гааль, гаалийн улсын байцаагчийн дүгнэлттэй холбоотой маргаан **1**, зохиогчийн барааны тэмдэг газрын заалттай холбоотой **1**, давж заалдах журмаар **19** бусад **19** хэргийг тус тус хянан шийдвэрлэжээ.

Тайлант хугацаанд иргэн, хуулийн этгээдээс хяналтын журмаар гаргасан гомдолд нийт **28,501,200** (хорин найман сая таван зуун нэг мянга хоёр зуу) төгрөгийг улсын тэмдэгтийн хураамжид төлсний **23,517,000** (хорин гурван сая таван зуун арван долоон мянга) төгрөгийг буцаан олгожээ.

2.ШҮҮН ТАСЛАХ АЖИЛЛАГААНААС БУСАД АЖИЛ:

2.1.Эрүүгийн хэргийн танхим

Боловсруулсан баримт бичиг:

№	Хариуцан гүйцэтгэсэн ажил	Шүүгчийн нэр
1.	“Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.15 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг тайлбарлах тухай” тогтоолыг боловсруулж, батлуулсан.	Шүүгч Б.Амарбаясгалан
2.	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.3, 16.5 дугаар зүйлийг зөв тайлбарлах тухай албан ёсны тайлбарыг Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцүүлж, тогтоолыг ёсчлуулахад хамтран ажилласан.	Шүүгч Б.Амарбаясгалан
3.	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөв тайлбарлах тухай албан ёсны тайлбарыг Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцүүлж, тогтоолыг ёсчлуулахад хамтран ажилласан.	Шүүгч Б.Амарбаясгалан
4.	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.3, 16.5 дугаар зүйлийн зарим заалтыг тайлбарлах тухай төсөл боловсруулахад оролцсон.	Шүүгч С.Батдэлгэр
5.	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.4 дүгээр зүйлийн заалтыг тайлбарлах тухай төсөл боловсруулахад оролцсон.	Шүүгч С.Батдэлгэр
6.	Нийт шүүгчийн хуралдаанд Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийг өөрчлөн найруулах хуулийн төсөлд саналаа оруулан илтгэсэн.	Шүүгч С.Батдэлгэр
7.	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.16 дугаар зүйлийн 1, 39.10 дугаар зүйлийн 4, 40.8 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн албан ёсны тайлбар гаргуулахаар ажиллаж байна.	Шүүгч Б.Батцэрэн
8.	Шүүгчийг татгалзан гаргах хүсэлтийг шийдвэрлэх журмын талаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 10.1, 10.2, 10.3, 10.4 дүгээр зүйлийн зарим хэсэг, заалтыг тайлбарлах тухай Улсын дээд шүүхийн тогтоолын төслийг боловсруулж, батлуулсан.	Шүүгч Б.Батцэрэн
9.	Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаар “Хялбаршуулсан журмаар эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдааны дэг, журам болон шүүхийн шийдвэр боловсруулах журам, аргачлал” боловсруулж, батлуулсан.	Шүүгч Б.Батцэрэн
10.	2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр Үндсэн хуулийн цэцэд “Цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ”-ний талаар тайлбар хүргүүлсэн.	Шүүгч Б.Батцэрэн
11.	Шүүх шинжилгээний тухай хууль /Шинэчилсэн найруулга/ болон Монгол Улсын шүүхийн тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу “Хүний сэтгэцэд учирсан хор уршгийг арилгах, нөхөн төлүүлэх төлбөрийн жишиг аргачлал”-ын журмыг батлуулсан.	Шүүгч М.Пүрэвсүрэн
12.	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөв хэрэглэх албан ёсны тайлбарын төсөл боловсруулан, Улсын дээд шүүхийн Нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулсан.	Шүүгч М.Пүрэвсүрэн

13.	Нийт шүүгчийн 2 дугаар чуулганыг зохион байгуулах ажлын хэсгийн гишүүнээр ажиллан, “Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох нийтлэг журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулахаар шүүхүүдээс ирүүлсэн саналыг нэгтгэн, томъёолол бэлтгэж, батлуулсан.	Шүүгч М.Пүрэвсүрэн
14.	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 1/4790 дүгээр албан бичгээр ирүүлсэн Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй холбогдох бусад хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд өгөх саналыг бэлтгэж, Нийт шүүгчийн хуралдаанаар танилцуулсан.	Шүүгч М.Пүрэвсүрэн
15.	УИХ-ын гишүүн С.Одонтуяагийн санаачлан боловсруулсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон мөн гишүүнээс ирүүлсэн ажлын бус цагаар жижүүрийн шүүгч ажиллуулахтай холбоотой албан бичгийг Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанд танилцуулж, саналыг нэгтгэн албан бичгийн төслийг боловсруулж, Ерөнхий шүүгчийн ажлын албанд хүргүүлсэн.	Шүүгч Д.Эрдэнэбалсүрэн
16.	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.3, 16.5 дугаар зүйл зарим хэсгийн албан ёсны тайлбарын тогтоолыг боловсруулж, батлуулсан.	Танхимын тэргүүн Ч.Хосбаяр
17.	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл, хэсэг Үндсэн хууль зөрчсөн тухай таван шүүгчийн саналыг Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцүүлж, тогтоолын төслийг боловсруулж, ёсчлуулсан.	Танхимын тэргүүн Ч.Хосбаяр

Бичсэн ном, гарын авлага:

№	Хариуцан гүйцэтгэсэн ажил	Шүүгчийн нэр
1.	2023 оны хуульчийн мэргэжлийн шалгалтын жишиг сорилгын хураамжийг хянан тохиолдуулсан.	Шүүгч Б.Амарбаясгалан
2.	2023 оны хуульчийн мэргэжлийн шалгалтад бэлтгэгчдэд зохиулсан “Эрх зүйн тохиолдол шийдвэрлэх аргачлал” гарын авлагыг хамтран зохиогчоор оролцсон.	Шүүгч Б.Амарбаясгалан
3.	“Шүүгчийн тусгай санал ба саналын тооны харьцааг нийтлэх шаардлага” сэдэвт эрдэм шинжилгээний өгүүллийг хамтран бичсэн.	Шүүгч Б.Амарбаясгалан

Мэргэшсэн чиглэлийн дагуу заасан хичээл:

№	Хариуцан гүйцэтгэсэн ажил	Шүүгчийн нэр
1.	2023.09.18, 19-ний өдөр Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах болон анхан шатны шүүхийн шүүгчдэд “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд баримтлах зарим зарчмууд” дэд сэдвийн хүрээнд сургалт удирдан явуулсан.	Шүүгч Б.Амарбаясгалан
2.	2023 онд зохион байгуулах “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд баримтлах зарим зарчмууд” сургалтын хөтөлбөр боловсруулсан.	Шүүгч Б.Амарбаясгалан
3.	2023 оны 07-09 дүгээр сарын хооронд Монголын Хуульчдын холбооноос зохион байгуулсан Хуульчийн сонгон шалгаруулалтад бэлтгэх Эрүүгийн эрх зүйн сургалтыг 8 удаа удирдан явуулсан.	Шүүгч Б.Амарбаясгалан

4.	2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр “Гэр бүлийн хүчирхийлэл” сэдвээр эрүүгийн хэргийн шүүхийн шүүгч нарт сургалт явуулсан.	Шүүгч Б.Батцэрэн
5.	2023 оны 02 дугаар сарын 02-ны өдөр давж заалдах шатны шүүгч нарт “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” сэдвээр хичээл заасан.	Шүүгч Б.Батцэрэн
6.	2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр Улсын ерөнхий прокурорын дэргэдэх Сургалт судалгааны хүрээлэнд “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах” гэмт хэргийн талаар Нийслэл, дүүргийн прокуроруудад хичээл заасан.	Шүүгч Б.Батцэрэн
7.	2023 оны 05 дугаар сарын 22-23-ны өдрүүдэд шинээр томилогдсон шүүгч нарт “Мэтгэлцэх зарчим, Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” сэдэвт сургалт явуулсан.	Шүүгч Б.Батцэрэн
8.	2023 оны 12 дугаар сарын 08-ны өдөр “Хуульчийн ёс зүй сэдэвт сургалтын хөтөлбөр” боловсруулсан.	Шүүгч Б.Батцэрэн
9.	2023 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр “Эрүүгийн хэрэг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх” сэдэвт сургалтыг эрүүгийн шүүгч нарт кредит олгох сургалт явуулсан.	Шүүгч Б.Батцэрэн
10.	2023 оны 06 дугаар сарын 09-10-ны өдрүүдэд Баруун бүсийн зарим аймгийн шүүхийн шүүгчидтэй уулзалт хийн, Улсын дээд шүүх хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах талаар хэрэгжүүлж буй арга хэмжээ болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тулгамдаж буй асуудлаар санал солилцон, хэлэлцүүлэг зохион байгуулж, “Хялбаршуулсан болон ердийн журмаар хянан шийдвэрлэсэн хэргийн ялын төрөл хэмжээний харьцуулсан судалгаа” сэдвээр хичээл заасан.	Шүүгч М.Пүрэвсүрэн
11.	2023 оны 07-09 дүгээр сарын хооронд Монголын Хуульчдын холбооноос зохион байгуулсан Хуульчийн сонгон шалгаруулалтад бэлтгэх Эрүүгийн эрх зүйн сургалтад Эрүүгийн хуулийн Хорьдугаар бүлэг “Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг”-Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, Эрүүгийн хуулийн Хорин дөрөвдүгээр бүлэг “Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг”-Хууль бусаар мод бэлтгэх гэмт хэргийн зүйлчлэл, анхаарах асуудлууд сэдвээр хичээл заасан.	Шүүгч М.Пүрэвсүрэн
12.	2023 оны 02 дугаар сарын 03-ны өдөр давж заалдах шатны шүүхийн шүүгчдийн сургалтыг “Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал бичих, боловсруулах аргачлал” дэд сэдвийн хүрээнд удирдан явуулсан.	Шүүгч Д.Эрдэнэбалсүрэн
13.	2023 оны 09 дүгээр сарын 18, 19-ний өдөр Нийслэлийн эрүүгийн хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчдэд “Анхан шатны шүүхийн шийтгэх (цагаатгах) тогтоол бичих, боловсруулах аргачлал” дэд сэдвийн хүрээнд сургалт удирдан явуулсан.	Шүүгч Д.Эрдэнэбалсүрэн
14.	“Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх (цагаатгах) тогтоол бичих, боловсруулах аргачлал ба нотлох баримтын агуулгыг тусгах арга зүй” сэдэвт 4 цагийн сургалтын хөтөлбөр боловсруулсан.	Шүүгч Д.Эрдэнэбалсүрэн
15.	2023.02.02-ны өдөр Эрүү, иргэний хэргийн Давж заалдах шатны шүүхийн шүүгчдэд “Шүүгчийг татгалзан гаргах тухай Улсын дээд шүүхийн тайлбар” дэд сэдвийн хүрээнд сургалт удирдан явуулсан.	Танхимын тэргүүн Ч.Хосбаяр

16.	2023.09.18, 19-ний өдөр Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах болон анхан шатны шүүхийн шүүгчдэд “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд баримтлах зарим зарчмууд” дэд сэдвийн хүрээнд сургалт удирдан явуулсан.	Танхимын тэргүүн Ч.Хосбаяр
17.	Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн Сургалтын хөтөлбөрийн хорооны орон тооны бус хорооны 5 удаагийн хуралд оролцсон.	Танхимын тэргүүн Ч.Хосбаяр

Оролцсон хурал, зөвлөгөөн, уулзалт, хэлэлцүүлэг:

№	Хариуцан гүйцэтгэсэн ажил	Шүүгчийн нэр
1.	Нийт шүүгчийн II-р чуулганд оролцсон.	Танхимын тэргүүн болон шүүгчид
2.	2023 оны 05 дугаар сарны 26-ны өдөр “Дипломат ёслол” сэдэвт сургалтад тус тус оролцсон байна.	
3.	2023 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр Ханнс Зайделийн сангаас зохион байгуулсан “Цахим нотлох баримт” сэдэвт сургалтад хамрагдсан. “Монгол-Германы эрх зүйн хамтын ажиллагаа” бага хуралд оролцсон.	
4.	“Монгол-Германы эрх зүйн хамтын ажиллагаа” сэдэвт бага хуралд оролцсон.	
5.	2023 оны 06 дугаар сарын 20-ны өдөр Хууль зүй, Дотоод хэргийн яамнаас зохион байгуулсан “Монгол Улсын Эрүүгийн бодлого:Эдүгээгийн байдал, шийдвэрлэвэл зохих асуудал” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хэлэлцүүлэгт оролцсон.	
6.	2023 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр Хүний эрхийн Үндэсний комисстой хамтран дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн зарим шүүгчидтэй уулзалт хийж, “Баривчлах, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ”-ний талаар хэлэлцүүлэг зохион байгуулсан.	
7.	2023 оны 02 дугаар сарын 16-ны өдөр Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх сэдвээр анхан болон давж заалдах шатны шүүгч нарт хэлэлцүүлэг хийсэн.	
8.	2023 оны 02 дугаар сарын 25-ны өдөр телевизийн “Ярьдаг хууль” нэвтрүүлэгт Эрүүгийн хуулийн шинэчлэл сэдлээр ярилцлагад орсон.	
9.	2023 оны 05 дугаар сарын 04-ний өдөр “Гамшгаас хамгаалах, гамшгаас урьдчилан сэргийлэх, Галын аюулгүй байдлын тухай, Гал түймрийн улсын хяналтын дүрэм, стандарт, норм, зааварчилгааг таниулах арга зүй”-н сургалтад хамрагдсан.	
10.	2023 оны 06 дугаар сарын 08-10-ны өдрүүдэд Архангай аймагт хангайн бүсийн шүүгч нарын уулзалт, хэлэлцүүлэгт оролцсон.	Шүүгч Б.Батцэрэн
11.	2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан “Авлигын гэмт хэргийг хянан шийдвэрлэхэд анхаарах асуудал” сэдэвт хэлэлцүүлэгт оролцсон.	Шүүгч Б.Батцэрэн
12.	2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр Улсын ерөнхий прокурорын дэргэдэх Сургалт судалгааны хүрээлэнд зохион байгуулсан Хуульчдад зориулсан сургалтын тогтолцоо, шинэчлэл сэдэвт хэлэлцүүлэгт оролцсон.	Шүүгч Б.Батцэрэн

13.	2023 оны 03 дугаар сарын 29-ний өдрөөс 30-ны өдөр ТАIЕХ-ийн хүрээнд хэрэгжих үйл ажиллагааны талаар Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо болон Европын холбооны гишүүн 4 улсын (Австри, Эстони, Итали, Испани) холбогдох удирдах байгууллагууд хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулсан шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг бэхжүүлэх зорилгын хүрээнд шүүхийн захиргаа болон хэргийн хөдөлгөөний удирдлагад цахимжуулалтыг нэвтрүүлэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогч бүх байгууллагын цахимжуулалтын бодлого, хэрэгжүүлэлтийг уялдуулахад Европын улсуудын шүүхийн цахимжуулалтын туршлага судлах, техникийн туслалцааны үйл ажиллагаа хэрэгжүүлэх Европын холбооны экспертүүдийн уулзалт, ярилцлагад оролцсон.	Шүүгч С.Соёмбо-Эрдэнэ
14.	2023 оны 09 дүгээр сарын 28, 29-ний өдрүүдэд Нийт шүүгчийн 2 дугаар чуулганыг зохион байгуулах ажлын хэсэгт орж ажиллан, “Эрүүгийн хэргийн шүүгчдийн нэгдсэн зөвлөгөөн”-д тус тус оролцсон.	Шүүгч М.Пүрэвсүрэн
15.	2023 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр “Сэжигтнийг баривчлах ажиллагааны өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал” сэдэвт хэлэлцүүлэгт тус тус оролцсон.	Шүүгч Д.Эрдэнэбалсүрэн
16.	БНКУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд Габит Койшибаев, зөвлөх Сабит Негметжанов нарыг 2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр хүлээн авч уулзсан.	Танхимын тэргүүн Ч.Хосбаяр
17.	Мөн Бүгд Найрамдах Киргизстан Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч Базербек Замирбек, Тамгын газрын дарга Мамыров Эркинбек Тобокелович, Ерөнхий шүүгчийн орлогч Мусаев Нурлан Алишерович нартай 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдөр цахим уулзалт зохион байгуулсан.	Танхимын тэргүүн Ч.Хосбаяр
18.	2023 оны 2 дугаар сарын 03-ны өдөр Канад Улсын Нью Брансвик мужийн Давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч Марк Ричард тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзсан.	Танхимын тэргүүн Ч.Хосбаяр
19.	Европын Холбооны Техникийн туслалцаа, мэдээлэл солилцох хөтөлбөрийн хүрээнд ажилласан Итали Улсын шүүгч Мариа Жулиана Сивинини, Австри Улсын шүүгч Гернот Пош тэргүүтэй төлөөлөгчдийг 2023 оны 3 дугаар сарын 29-ний өдөр хүлээн авч уулзсан.	
20.	2023 оны 06 дугаар сарын 09-10-ны өдрүүдэд Баруун бүсийн зарим аймгийн шүүхийн шүүгчидтэй уулзаж, Улсын дээд хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах талаар хэрэгжүүлж буй арга хэмжээ болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тулгамдаж буй асуудлаар санал солилцсон.	Танхимын тэргүүн Ч.Хосбаяр
21.	Хүний эрхийн үндэсний хорооны уулзалт, семинарт оролцсон.	
22.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагддаг “Хүний эрхийн үндэсний форум”-д давж заалдах болон анхан шатны шүүхийн шүүгч нарын хамт оролцсон.	
23.	“Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд баримтлах зарим зарчмууд” сэдэвт 0.5 кредиттэй сургалтын хөтөлбөрийг боловсруулсан.	Танхимын тэргүүн Ч.Хосбаяр

		Шүүгч Б.Амарбаясгалан
--	--	--------------------------

Ажлын хэсгийн оролцоо:

№	Хариуцан гүйцэтгэсэн ажил	Шүүгчийн нэр
1.	2022 оны 12 сарын 23-ны өдөр батлагдсан Шүүх шинжилгээний тухай хууль /Шинэчилсэн найруулга/ болон Монгол Улсын шүүхийн тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу “Хүний сэтгэгцэд учирсан хор уршгийг арилгах, нөхөн төлүүлэх төлбөрийн жишиг аргачлал”-ын журмыг боловсруулах ажлын хэсэгт орж ажилласан.	Танхимын тэргүүн Ч.Хосбаяр, шүүгч М.Пүрэвсүрэн
2.	2023 онд Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх ажлын хэсэгт 3 удаа оролцсон.	Танхимын тэргүүн Ч.Хосбаяр, шүүгч Б.Батцэрэн, М.Пүрэвсүрэн
3.	Монгол Улсын дээд шүүхийн цахимжилт ажлын хэсэгт орон саналаа өгч ажиллаж байна.	Шүүгч Б.Батцэрэн, М.Пүрэвсүрэн
4.	Монголын хуульчдын холбооны Хуульчийн мэргэжлийн шалгалтын асуудал эрхэлсэн хорооны даргаар сонгогдон 2023 оны 10 дугаар сарын 26-28-ны өдрүүдэд зохион байгуулагдсан хуульчийн мэргэжлийн шалгалтыг зохион байгуулах, дүгнэх комиссыг ахлан ажилласан.	Шүүгч Б.Амарбаясгалан
5.	2023 оны 10 дугаар сарын 28-29-нд, 11 дүгээр сарын 04-нд Монголын Хуульчдын холбооноос зохион байгуулсан Хуульчийн сонгон шалгаруулалтад Эрүүгийн эрх зүйн бодлого дүгнэх комиссын ахлагчаар ажилласан.	Шүүгч Б.Батцэрэн
6.	Давж заалдах шатны шүүх хуралдаанд бэлтгэх ажлын бүрдэл, хугацааны хуваарилалт, дарааллыг тогтоох, бэлтгэх хуралдаан хийх журам боловсруулах ажлын хэсэгт ажилласан.	Шүүгч С.Соёмбо-Эрдэнэ
7.	Нийт шүүгчийн 2 дугаар чуулганыг зохион байгуулах ажлын хэсгийн гишүүнээр ажиллан, “Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох нийтлэг журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулахаар шүүхүүдээс ирүүлсэн саналыг нэгтгэн, томъёолол бэлтгэж, батлуулсан.	Шүүгч М.Пүрэвсүрэн
8.	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахтай холбоотой “Сэжигтнийг баривчлах, цагдан хорих” талаар санал боловсруулж ажилласан.	Шүүгч М.Пүрэвсүрэн
9.	Улсын дээд шүүхийн тамгын газрын бүтэц, орон тоог батлах ажлын хэсэгт орж ажиллаж байна.	Шүүгч М.Пүрэвсүрэн
10.	Монгол Банкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан Санхүүгийн мэдээллийн албаны дэргэдэх “Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх” хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүнээр ажиллаж байна.	Шүүгч Д.Эрдэнэбалсүрэн
11.	“Гүйцэтгэх ажилд тавих Улсын их хурлын хяналтын тухай хуулийн төсөл боловсруулах дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүн”-д оролцсон.	Танхимын тэргүүн Ч.Хосбаяр

Контент бүтээх ажлын оролцоо:

№	Хариуцан гүйцэтгэсэн ажил	Шүүгчийн нэр
---	---------------------------	--------------

1.	2023.12.11-ний өдөр Эрүүгийн хэргийн шүүхийн шүүгчдийн заавал судлах “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд баримтлах зарим зарчмууд” сэдэвт цахим хичээлийн бичлэгийг хийлгэсэн.	Шүүгч Б.Амарбаясгалан
2.	2023 оны 4-6 сард цагдан хорих зөвшөөрөл олгох, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг явуулах, үндсэн шүүх хуралдаан болон эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг хянан шийдвэрлэх, хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх шүүх хуралдааныг мэтгэлцэх зарчмын дагуу хэрхэн явуулах талаар сургалтын бие даасан 5 контент хийх ажлыг санаачлан зохион байгуулж, “Азийн сан” байгууллагын санхүүжилтээр, бусад байгууллагуудтай хамтран бүтээхэд оролцсон.	Шүүгч Б.Батцэрэн
3.	2023 онд Шүүхийн сургалт судалгааны хүрээлэн, Улсын ерөнхий прокурор, Монголын Хуульчдын холбоо хамтран Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлэх сургалтын 6 контентыг хийж, цахимд байршуулсан.	Шүүгч Б.Батцэрэн
4.	<u>ERDENEALSUREN Damdin (supremecourt.mn)</u> хаягаар Олон Улсын Эрүүгийн шүүхийн шүүгчийн нэр дэвшигчийн сонгуультай холбогдуулан бүтээсэн контент боловсруулсан.	Шүүгч Д.Эрдэнэбалсүрэн
5.	Олон Улсын Эрүүгийн шүүхийн шүүгчээр сонгогдсонтой холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчтэй уулзалт хийж, тухайн ярилцлагыг eagle, ntv, малчин сувгууд дамжуулан хүргэсэн.	Шүүгч Д.Эрдэнэбалсүрэн
6.	“Ээлжийн шүүгч ажиллах” талаар eagle сувагт ярилцлага өгсөн.	Танхимын тэргүүн Ч.Хосбаяр
7.	“Үндэсний хөтөч” сэдвээр eagle сувагт ярилцлага өгсөн.	
8.	2023.05.19-ний өдөр Анхан шатны шүүхэд шинээр томилогдсон шүүгчийг мэргэшүүлэн дадлагажуулах сургалтын семинарыг “Нотлох баримт, түүнийг үнэлэх” дэд сэдвийн хүрээнд удирдан явуулсан, мөн тус сэдвээр сургалтын видео контент бичүүлсэн.	Танхимын тэргүүн Ч.Хосбаяр
9.	МУИС-ийн багш Т.Золбоогийн хамт Эрүүгийн хуулийн хэрэглээ ба субсумци хийх аргачлал сэдвээр контент хийж, legaldata-д байршуулсан.	Танхимын тэргүүн Ч.Хосбаяр

Гадаад хурал, зөвлөгөөн, илтгэл, албан томилолт:

№	Хариуцан гүйцэтгэсэн ажил	Шүүгчийн нэр
1.	БНСУ-ын Шүүхийн сургалт, судалгааны хүрээлэнгийн урилгаар 2023 оны 4 дүгээр сарын 24-28-ны өдрүүдэд “БНСУ-ын шүүхийн цахимжилт” сэдвийн хүрээнд сургалтад хамрагдсан.	Шүүгч С.Соёмбо-Эрдэнэ
2.	2023.10.30-2023.11.03-ны өдрийн хооронд БНСУ-д албан томилолтоор ажилласан.	Шүүгч М.Пүрэвсүрэн
3.	Ерөнхий шүүгч Д.Ганзоригийн хамт 2023 оны 01 дүгээр сарын 17-20-ны өдрүүдэд Нидерландын Хаант Улсын Гаг хотод зохион байгуулагдсан Олон Улсын Эрүүгийн Шүүхийн “Шүүхийн жилийн нээлт” арга хэмжээнд оролцох, хоёр талын уулзалт хийх зорилгоор айлчилсан.	Шүүгч Д.Эрдэнэбалсүрэн
4.	2023 оны 05 дугаар сарын 15-26-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Словени Улсад зохион байгуулагдсан “Онц ноцтой гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн харилцан туслалцаа	Шүүгч Д.Эрдэнэбалсүрэн

	үзүүлэх тухай конвенц батлах” тухай дипломат айлчлалд тус тус оролцсон.	
5.	Нидерландын Хаант Улсын Гааг хотод 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдөр зохион байгуулагдсан Олон Улсын Эрүүгийн шүүхийн шүүгчийн нэр дэвшигчийн урьдчилсан ярилцлагад оролцсон.	Шүүгч Д.Эрдэнэбалсүрэн
6.	Олон Улсын Эрүүгийн шүүхийн шүүгчийн нэр дэвшигчийн сонгуульт ажилтай холбогдуулан Европын улсуудад 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөс 11 дүгээр сарын 10-ны өдрийг хүртэл хугацаанд айлчлал хийсэн.	Шүүгч Д.Эрдэнэбалсүрэн
7.	Олон Улсын Эрүүгийн шүүхийн шүүгчийн нэр дэвшигчийн сонгуулийн санал хураалт Нью-Йорк хотноо 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн зохион байгуулагдаж, эхний санал хураалтаар 81 орны санал авч Олон Улсын Эрүүгийн шүүхийн шүүгчээр 2024-2033 оныг хүртэл хугацаагаар сонгогдсон.	Шүүгч Д.Эрдэнэбалсүрэн
8.	Олон улсын эрүүгийн шүүхээс Бүгд Найрамдах Солонгос Улсын Сөүл хотод 2023 оны 11 дүгээр сарын 13-наас 16-ны өдрүүдэд зохион байгуулсан “Олон улсын эрүүгийн шүүх ба Ази-Номхон далай: Ромын дүрмийн өнгөрсөн, одоо, ирээдүй бүс нутгийн нэгдмэл байдлын төлөөх алсын хараа” сэдэвт өндөр түвшний зөвлөгөөнд оролцсон.	Танхимын тэргүүн Ч.Хосбаяр

Бусад:

№	Хариуцан гүйцэтгэсэн ажил	Шүүгчийн нэр
1.	Монголын хуульчдын холбооны Шүүгчдийн хорооны удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдон ажилласан.	Шүүгч Б.Амарбаясгалан
2.	Хууль зүй, Дотоод хэргийн яамнаас ирүүлсэн Шинжилгээний объект хүргүүлэх, хадгалах журам болон шинжилгээний байгууллагад хийх шинжилгээний жагсаалтын төсөлд санал хүргүүлсэн.	Шүүгч Б.Амарбаясгалан
3.	Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Стандарт, хэмжил зүйн газраас ирүүлсэн “Насанд хүрээгүй гэрч, хохирогчийг хамгаалах стандарт”-ын төсөлд өгөх саналыг нэгтгэн хүргүүлсэн.	Шүүгч Б.Амарбаясгалан
4.	Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайдаас ирүүлсэн Ялтан шилжүүлэх тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Куба Улс хоорондын гэрээний төсөл, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөлд өгөх саналыг нэгтгэн хүргүүлсэн.	Шүүгч Б.Амарбаясгалан
5.	Хууль зүй, дотоод хэргийн яамны төрийн нарийн бичгийн даргаас ирүүлсэн Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг Нэмэлт Протоколын 4 дүгээр зүйлийн Ерөнхий тайлбар 1-ийн төсөлд өгөх саналыг нэгтгэн хүргүүлсэн	Шүүгч Б.Амарбаясгалан
6.	Шүүхийн сургалт, судалгаа мэдээллийн хүрээлэнгээс ирүүлсэн хяналтын шатны шүүхийн шүүгчдийн сургалтын хэрэгцээ, шаардлагын судалгаанд хамрагдсан.	Шүүгч Б.Амарбаясгалан
7.	ҮХЦ-с ирүүлсэн Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт ҮХ-ийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх талаар тайлбар гаргуулах асуудлыг Танхимын нийт шүүгчийн зөвлөгөөнөөр хэлэлцүүлсэн саналыг авч нэгтгэн, тайлбарыг хүргүүлсэн.	Шүүгч С.Батдэлгэр

8.	Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн гишүүний хувьд 2022 онд Анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн өсвөр насны ял шийтгүүлэгчдийн талаарх судалгааг хийж хүргүүлсэн.	Шүүгч С.Батдэлгэр
9.	2023 оны 02 дугаар сарын 25-ны өдөр телевизийн “Ярьдаг хууль” нэвтрүүлэгт Эрүүгийн хуулийн шинэчлэл сэдлээр ярилцлагад орсон.	Шүүгч Б.Батцэрэн
10.	2023 оны 03 дугаар сарын 02-ны өдөр Шүүх эрх мэдлийн шинэчлэл, цахим шүүх сэдэвт сургалт явуулсан.	Шүүгч Б.Батцэрэн
11.	2023 оны 07-09 дүгээр сарын хооронд Монголын Хуульчдын холбооноос зохион байгуулсан Хуульчийн сонгон шалгаруулалтад бэлтгэх Эрүүгийн эрх зүйн сургалтыг 9 удаа зохион байгуулсан.	Шүүгч Б.Батцэрэн
12.	2023 оны 12 дугаар сарын 11-ний өдөр Монголын хуульчдын холбоо, Монголын Шүүгчдийн холбоо хамтран зохион байгуулсан Эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхэд анхаарах асуудал сэдэвт хэлэлцүүлэгт Эрүүгийн хэрэг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт сэдвээр илтгэл тавьсан.	Шүүгч Б.Батцэрэн
13.	2023 оны 12 дугаар сарын 13-ны өдөр Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Гэр бүл, Залуучуудын хөгжлийн газрын удирдах ажилтнуудад Хүүхдэд холбогдох хэрэгт анхаарах асуудал сэдлээр сургалт явуулсан.	Шүүгч Б.Батцэрэн
14.	2023.08.23-ны өдрөөс 2023.08.29-ний өдрийг хүртэл хугацаанд Баян-Өлгий аймаг руу томилолтоор явж, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн А/268, А/275 дугаар хамтарсан тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Хүний сэтгэцэд учирсан хор уршгийг арилгах, нөхөн төлүүлэх төлбөрийн жишиг аргачлал журам”-ын хэрэгжилтийн хүрээнд Баян-Өлгий аймаг дахь анхан болон давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгчидтэй уулзалт хийж, хэлэлцүүлэг явуулсан.	Шүүгч М.Пүрэвсүрэн
15.	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төсөлд тус тус санал боловсруулсан.	Шүүгч М.Пүрэвсүрэн
16.	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 10.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Эрүүгийн хэргийг анхан шатны, давж заалдах, хяналтын журмаар хянан шийдвэрлэхэд оролцсон шүүгч уг хэргийг өөр шатны журмаар хянан шийдвэрлэхэд оролцож болохгүй” гэсэн үндэслэлээр 21 татгалзан гарах хүсэлт гаргасан.	Танхимын тэргүүн Ч.Хосбаяр
17.	Бүгд Найрамдах Турк Улсын Хууль зүйн дэд сайд Хасан Илмаз болон түүний төлөөлөгчдийг 2023 оны 10 дугаар сарын 5-ны өдөр хүлээн авч уулзаж, хамтын ажиллагааны талаар;	
18.	Шүүхийн шийдвэрийн хураангуйг боловсруулсан.	
19.	Эрүүгийн хэргийн шүүхийн шүүгчдийн анхдугаар хурлыг зохион байгуулж, санал солилцов.	
20.	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр төлөвлөгөөнд санал нэгтгэж хүргүүлэв.	
21.	Шүүгч, өмгөөлөгчдийн хараат бус байдал хариуцсан НҮБ-ын Тусгай илтгэгчийн айлчлалын хүрээнд Шүүх эрх мэдлийн салбарын хүрээнд хэрэгжиж буй бодлого,	

	хийгдсэн ажил, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх саналыг боловсруулав.	
22.	Хууль зүй, Дотоод хэргийн яамнаас ирүүлсэн Шинжилгээний объект хүргүүлэх, хадгалах журам болон шинжилгээний байгууллагад хийх шинжилгээний жагсаалтын төсөлд саналыг нэгтгэж, хүргүүлсэн.	
23.	Эрүүгийн хууль, Зөрчлийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг УДШНШХ-аар хэлэлцүүлж, саналыг нэгтгэн хүргүүлэх ажлыг зохион байгуулсан.	
24.	Орон нутгийн шүүхийн шүүгчдийн татгалзан гарах тухай 17 хүсэлтийг танхимын зөвлөгөөнөөр хэлэлцүүлж, харьяалал тогтоон шилжүүлсэн.	
25.	ЭХХШТхуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн баривчлах, цагдан хорихтой холбоотой хэсэгт оруулах санал боловсруулсан.	Шүүгч С.Соёмбо-Эрдэнэ
26.	Улс төрийн намын шинэчилсэн найруулга хуулийн төсөлд санал өгсөн.	Шүүгч С.Соёмбо-Эрдэнэ
27.	Шүүх байгуулах тухай хууль болон бусад хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд санал өгсөн.	Шүүгч С.Соёмбо-Эрдэнэ
28.	“Шинжилгээний объект устгах, хүргүүлэхтэй холбоотой журам”-ын төсөлд санал өгсөн.	Шүүгч С.Соёмбо-Эрдэнэ
29.	Улсын тэмдэгтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд санал өгсөн.	Шүүгч С.Соёмбо-Эрдэнэ

2.2.ИРГЭНИЙ ХЭРГИЙН ТАНХИМ

Боловсруулсан баримт бичиг:

№	Хариуцан гүйцэтгэсэн ажил	Шүүгчийн нэр
1.	2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 05 дугаар тогтоолоор “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 84, 91, 92 дугаар зүйлийн зарим хэсэг, заалтыг тайлбарлах тухай	Иргэний хэргийн танхимын шүүгчид
2.	2023 оны 04 дүгээр сарын 14-ны өдрийн 17 дугаар тогтоолоор “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн <u>38, 120, 124, 166, 167 дугаар зүйлийн зарим заалтыг тайлбарлах тухай</u>	Иргэний хэргийн танхимын шүүгчид

Ажлын хэсгийн оролцоо:

№	Хариуцан гүйцэтгэсэн ажил	Шүүгчийн нэр
1.	“Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах” ажлын хэсгийн гишүүнээр	Танхимын тэргүүн Г.Алтанчимэг, шүүгч Н.Баярмаа, П.Золзаяа
2.	“Хүний сэтгэцэд учирсан хор уршгийг арилгах, нөхөн төлүүлэх төлбөрийн жишиг аргачлалыг боловсруулах” ажлын хэсгийн гишүүнээр	Шүүгч Н.Баярмаа, П.Золзаяа
3.	“Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны дэг болон Монгол Улсын дээд шүүхийн Шүүгчдийн зөвлөгөөний дэгд өөрчлөлт оруулах” ажлын хэсэгт	Шүүгч Н.Баярмаа, П.Золзаяа
4.	“Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын тухай” хуулийн төслийн ажлын хэсгийн гишүүнээр	Шүүгч Н.Баярмаа, П.Золзаяа
5.	Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн сэтгүүл, өгүүлэл дүгнэх ажлын хэсэгт	Шүүгч П.Золзаяа

6.	Монголын хуульчдын холбооны хуульчийг сонгон шалгаруулах, дүгнэх ажлын хэсэгт	Шүүгч П.Золзаяа
7.	“Давж заалдах шатны шүүх хуралдаанд бэлтгэх ажлын бүрдэл, хугацааны хуваарилалт, дарааллыг тогтоох, бэлтгэл хуралдаан хийх журам”-н ажлын хэсэгт	Шүүгч П.Золзаяа
8.	“Улсын дээд шүүхэд хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаан даргалагчийг сугалаагаар томилох журамд өөрчлөлт оруулах тухай” ажлын хэсэгт	Шүүгч П.Золзаяа, Н.Баярмаа

Оролцсон хурал, зөвлөгөөн, уулзалт, хэлэлцүүлэг:

№	Хариуцан гүйцэтгэсэн ажил	Шүүгчийн нэр
1.	Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо болон Европын холбооны гишүүн 4 улсын (Австри, Эстони, Итали, Испани) холбогдох удирдах байгууллагууд хамтын ажиллагааны хүрээнд 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдрөөс 30-ны өдөр зохион байгуулсан шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг бэхжүүлэх зорилгын хүрээнд шүүхийн захиргаа болон хэргийн хөдөлгөөний удирдлагад цахимжуулалтыг нэвтрүүлэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогч бүх байгууллагын цахимжуулалтын бодлого, хэрэгжүүлэлтийг уялдуулахад Европын улсуудын шүүхийн цахимжуулалтын туршлага судлах, техникийн туслалцааны үйл ажиллагаа хэрэгжүүлэх Европын холбооны экспертүүдийн уулзалт, ярилцлагад танхимын шүүгчид оролцож, санал солилцсон	Иргэний хэргийн танхимын шүүгчид
2.	Чингэлтэй дүүргийн шүүх үүсч байгуулагдсаны 30 жилийн ойн хүрээнд тус шүүхээс Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөлтэй хамтран 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдөр “Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тулгамдсан асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулсан бөгөөд уг хуралд танхимын тэргүүн Г.Алтанчимэг паналистаар оролцож, шүүгч Н.Баярмаа “Хэргийг ялгаатай удирдах зарчим буюу хэрэг хянан шийдвэрлэх хялбар ажиллагаа” сэдэвт эрдэм шинжилгээний илтгэл хэлэлцүүлсэн;	Танхимын тэргүүн Г.Алтанчимэг, шүүгч Н.Баярмаа
3.	Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн Сургалтын хөтөлбөрийн хорооны 4 удаагийн хуралдаанд оролцсон;	Танхимын тэргүүн Г.Алтанчимэг
4.	2023 оны 06 дугаар сарын 09-ний өдөр Архангай, Өвөрхангай, Баянхонгор аймаг дахь анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчидтэй хийх бүсчилсэн уулзалтад оролцож, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд тулгамдаж буй асуудал болон Улсын дээд шүүхийн гаргасан хуулийн тайлбартай холбоотой сургалтыг тус тус зохион явуулсан;	Танхимын тэргүүн Г.Алтанчимэг, шүүгч Н.Баярмаа, Х.Эрдэнэсүвд
5.	2023 оны 06 дугаар сарын 19-ний өдөр Төв аймгийн болон Нийслэлийн дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгчидтэй, мөн сарын 20-ны өдөр Төв аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх болон Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчидтэй тус тус уулзалт зохион байгуулж, хуулийн тайлбар, хууль хэрэглээний нэгдмэл ойлголт	Иргэний хэргийн танхимын шүүгчид

	болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тулгамдсан асуудлын талаар санал солилцсон;	
6.	Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхээс хууль хэрэглээний практик ойлголтыг нэгтгэхтэй холбоотой уулзалтыг Улсын Дээд шүүхтэй хамтран зохион байгуулах тухай, /2 удаагийн уулзалт/	
7.	“Шүүхийн практик судлал” хэлэлцүүлэгт “Хууль тайлбарласан ижил төстэй тогтоолыг тодорхойлох арга зүй” сэдэвт илтгэл хэлэлцүүлсэн.	Шүүгч П.Золзаяа
8.	ЕБС-ийн сургуулийн сурагчдыг хүлээн авч уулзсан.	Танхимын тэргүүн Г.Алтанчимэг
9.	БНСУ-ын Шүүхийн сургалт, судалгааны хүрээлэнгийн урилгаар 2023 оны 4 дүгээр сарын 24-28-ны өдрүүдэд тус улсын Сөүл хотноо “БНСУ-ын шүүхийн цахимжилт” сэдэвт сургалт, айлчлалд тус тус оролцсон.	Танхимын тэргүүн Г.Алтанчимэг, шүүгч Н.Баярмаа П.Золзаяа, Д.Цолмон, Х.Эрдэнэсүвд
10.	Гадаад харилцааны яамны Консулын газраас 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулсан “Дипломат ёслол” сэдэвт сургалтад хамрагдсан.	
11.	ХБНГУ-ын Бавари мужийн Пассау хотын Давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч, ноён Рүдольф Хэлмхагэн удирдан явуулсан “Арилжааны эрх зүй 1, 2”, “Даатгалын эрх зүй”, “Үүргийн гүйцэтгэлийг хангах арга, Баталгаа, банкны баталгаа” сэдэвт сургалтуудад танхимын шүүгчид 2023 оны 06 дугаар сарын 12-15-ны өдрүүдэд хамрагдсан.	Иргэний хэргийн танхимын шүүгчид
12.	ХБНГУ-улс руу албан томилолт /GIZ/	Танхимын тэргүүн Г.Алтанчимэг, шүүгч Н.Баярмаа, П.Золзаяа, Х.Эрдэнэсүвд
13.	БНАЛУ-улс руу албан томилолт	Шүүгч П.Золзаяа

Мэргэшсэн чиглэлийн дагуу заасан хичээл:

№	Хариуцан гүйцэтгэсэн ажил	Шүүгчийн нэр
1.	“Шүүгчийг татгалзан гаргах тухай Улсын дээд шүүхийн тайлбар болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль хэрэглэхтэй холбоотой бусад асуудал”	Танхимын тэргүүн Г.Алтанчимэг
2.	“Иргэний хуулийн хэрэглээтэй холбоотой анхаарах асуудал”	Шүүгч Н.Баярмаа
3.	“Шүүхийн шийдвэр боловсруулах аргачлалын үндэс, түүнийг заавал баримтлах учир шалтгаан, аргачлалыг баримтлаагүйгээс шүүхийн практикт үүссэн сөрөг үр дагавар”	Шүүгч П.Золзаяа
4.	“Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал бичих, боловсруулах аргачлал”,	Шүүгч П.Золзаяа
5.	“Онцгой ажиллагааны журмаар хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд анхаарах зарим асуудал” сэдвээр 2023.02.02-2023.02.03-ны өдрүүдэд зохион байгуулагдсан	Шүүгч Х.Эрдэнэсүвд

	Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчдэд зориулсан сургалтыг тус тус удирдан явуулсан	
6.	“Гэр бүлийн эрх зүй, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” 2022 оны сургалтын гарын авлагыг хянан тохиолдуулж, ажлын хэсэгт зохиогчоор ажилласан;	Шүүгч П.Золзаяа, Н.Баярмаа, Х.Эрдэнэсүвд
7.	“Арилжааны эрх зүй 1, 2”, “Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал бичих, боловсруулах аргачлал”, “Санхүүгийн түрээсийн гэрээ” сэдэвт сургалтын хөтөлбөрийг тус тус боловсруулан, батлуулсан	Танхимын тэргүүн Г.Алтанчимэг, шүүгч Н.Баярмаа, П.Золзаяа, Х.Эрдэнэсүвд
8.	2023 оны шүүгч нарын сургалтад хичээл заасан	Танхимын тэргүүн Г.Алтанчимэг, шүүгч Н.Батзориг, Н.Баярмаа, П.Золзаяа, Х.Эрдэнэсүвд
9.	“Эрх зүйн хөтөч” нэвтрүүлгийн зээлийн шимтгэл зохиомжийг хянаж, удирдсан	Шүүгч П.Золзаяа

Бусад:

№	Хууль болон журмын төсөл	Шүүгчийн нэр
1.	Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгээс эрхлэн гаргадаг Төр, Эрх зүй сэтгүүлийн 4 нийтлэлийг хянан тохиолдуулж, редактораар ажилласан	Шүүгч Д.Цолмон
2.	Шүүх байгуулах тухай хуулийн төсөлд санал	Иргэний хэргийн танхимын шүүгчид
3.	Арилжааны хуулийн төсөлд санал	
4.	“Тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа”-ны хуулийн төсөлд санал	
5.	Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүний сугалаагаар томилох нийтлэг журамд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбоотой УДШ-ийн нийт шүүгчийн хуралдаанд оруулах санал	
Нийт шүүгчийн хуралдаанд асуудал илтгэх		
6.	2023.10.18-нд Хууль зүй, дотоод хэргийн сайдын дугаар албан бичгээр ирүүлсэн Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд санал өгөх,	Танхимын тэргүүн Г.Алтанчимэг
7.	2023.10.18-нд Шинээр томилогдсон шүүгч нарыг танхимд хуваарилах	Танхимын тэргүүн Г.Алтанчимэг
8.	2023.06.26-нд Хүний сэтгэцэд учирсан хор уршгийг арилгах, нөхөн төлүүлэх төлбөрийн аргачлал батлах тухай асуудлыг тус тус илтгэсэн байна.	Шүүгч Н.Баярмаа
9.	2023.10.02-нд Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.7-д заасан асуудлыг хэлэлцэх,	Шүүгч Н.Баярмаа
10.	2023.10.09-нд Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 1/4790 дүгээр албан бичгээр ирүүлсэн Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн	Шүүгч Н.Баярмаа

	найруулга/-ийн төсөлтэй холбогдох бусад хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл,	
11.	2023.10.09-нд Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийн зарим асуудлаар зөвшилцөхөөр ирүүлсэн саналыг хэлэлцэх тухай асуудлыг тус тус илтгэсэн байна.	Шүүгч Н.Баярмаа
12.	2023.06.26-нд Хүний сэтгэцэд учирсан хор уршгийг арилгах, нөхөн төлүүлэх төлбөрийн аргачлал батлах,	Шүүгч П.Золзаяа
13.	2023.10.09-нд “Давж заалдах шатны шүүх хуралдаанд бэлтгэх ажлын бүрдэл, хугацааны хуваарилалт, дарааллыг тогтоох, бэлтгэл хуралдаан хийх журам”-ын төслийг танилцуулж, санал авах,	Шүүгч П.Золзаяа
14.	2023.10.18-нд Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 1/5214 дүгээр албан бичгээр ирүүлсэн Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлд санал өгөх тухай асуудлыг тус тус илтгэсэн байна.	Шүүгч П.Золзаяа

2.3.ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ТАНХИМ

Боловсруулсан баримт бичиг:

№	Хариуцан гүйцэтгэсэн ажил	Шүүгчийн нэр
1.	Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3, 18.3.1, 18.3.2, 52 дугаар зүйлийн 52.5.3, 54 дүгээр зүйлийн 54.1.1, 54.1.5, 83 дугаар зүйлийн 83.1, 106 дугаар зүйлийн 106.3.5, 106.5 дахь заалтуудын зарим хэсгийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар;	Захиргааны хэргийн танхимын шүүгчид
2.	Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.6, 61 дүгээр зүйлийн 61.1, 62 дугаар зүйлийн 62.1, 111 дүгээр зүйлийн 111.1, 111.3, 114 дүгээр зүйлийн 114.1, 119 дүгээр зүйлийн 119.5, 122 дугаар зүйлийн 122.1, 122.5, 122.6.3 дахь хэсгийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар;	Захиргааны хэргийн танхимын шүүгчид
3.	Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.8, 36.9 дэх хэсгийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар;	Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа
4.	Шүүхийн ёс зүйн зөвлөх хорооны ажиллах журам;	Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа
5.	Хуулийн төсөлд санал боловсруулсан (Шүүхийн тухай хууль, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Өмгөөллийн хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль)	Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа
6.	Нийт шүүгчийн ээлжит хоёрдугаар чуулганы даргалагчаар сонгогдон ажиллаж, чуулганаас гаргасан зөвлөмж, тогтоол, албан бичгүүдийг хянан баталгаажуулахад оролцсон.	Шүүгч Д.Батбаатар
7.	Нийт шүүгчийн ээлжит хоёрдугаар чуулганыг зохион байгуулах ажлын хэсгийн ахлагчаар ажилласан. Зөвлөмж, тогтоол, албан бичиг гэх мэт 80-аад эрх зүйн актын төсөл боловсруулах, хянан баталгаажуулахад оролцсон.	Шүүгч М.Батсуурь
8.	Монголын Улсын шүүхийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.1, 50.1.23 дахь заалттай холбоотой Үндсэн хуулийн цэцээс ирүүлсэн хариу тайлбар гаргуулах албан бичигт, судалгаа хийлгэж, танилцуулга бэлтгэн, нийт шүүгчийн	Шүүгч Х.Батсүрэн

	хуралдаанд илтгэж, Үндсэн хуулийн цэцэд хариу тайлбарыг хүргүүлсэн.	
9.	Давж заалдах шатны шүүх хуралдаанд бэлтгэх ажлын бүрдэл, хугацааны хуваарилалт, дарааллыг тогтоох, бэлтгэл хуралдаан хийх журмын төсөл бэлтгэсэн.	Шүүгч Ц.Цогт
10.	Улс төрийн намын бүртгэл хөтлөх журамд нэмэлт өөрчлөлт оруулах төслийг боловсруулж, батлуулсан,	Шүүгч П.Соёл-Эрдэнэ

Мэргэшсэн чиглэлийн дагуу заасан хичээл:

№	Хариуцан гүйцэтгэсэн ажил	Шүүгчийн нэр
1.	2023.02.02-ны өдөр Давж заалдах шатны шүүхийн шүүгчдийн сургалтыг “Шүүхийн шийдвэрийн хураангуй бэлтгэх аргачлал” дэд сэдвийн хүрээнд удирдан явуулсан.	Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа
2.	2023.03.24-ний өдөр нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч нарт “Шүүхийн шийдвэрийн хураангуй бичих аргачлал” сэдвээр сургалт;	Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа
3.	2023.04.24-ний өдөр “Шүүхийн шийдвэрийн хураангуй бичих арга зүй” сэдвээр сургагч багш нарт цахим сургалтыг тус тус явуулсан.	Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа
4.	2023.10.02-2023.10.03-ны өдөр Захиргааны хэргийн давж заалдах болон анхан шатны шүүхийн шүүгчдэд “Захиргааны хэргийн шүүхийн шүүгчдийн хууль хэрэглээний нэгдмэл байдал” дэд сэдвийн хүрээнд сургалт удирдан явуулсан.	Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа
5.	МХХ-ноос зохион байгуулсан “Төрийн албаны тухай хууль хэрэглээ” хуульчдын үргэлжилсэн сургалт;	Шүүгч П.Соёл-Эрдэнэ
6.	МХХ-ноос зохион байгуулсан шинэ хуульчдад зориулсан “Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах төрлүүд”, “төрийн албаны маргаан” сэдэвт 2 цагийн сургалт;	Шүүгч П.Соёл-Эрдэнэ
7.	Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн болон Азийн сангийн хамтран зохион байгуулсан шинэ шүүгчийн сургалтад “Захиргааны хэргийн шүүхэд гаргах нэхэмжлэлийн төрөл, түүнд тавигдах шаардлага” сургалт;	Шүүгч П.Соёл-Эрдэнэ
8.	МХХ-ноос зохион байгуулсан “Захиргааны хэргийн шүүхийн хяналтын цар хүрээ” сэдэвт хуульчийн үргэлжилсэн сургалт;	Шүүгч П.Соёл-Эрдэнэ
9.	МХХ-ноос зохион байгуулсан “Захиргааны үйл ажиллагааны зарчим” сэдэвт хуульчийн үргэлжилсэн сургалт;	Шүүгч П.Соёл-Эрдэнэ
10.	МХХ-ноос зохион байгуулсан “Сонгуулийн маргаан ба шүүхийн практик” сэдэвт хуульчийн үргэлжилсэн сургалт орж хичээл заасан.	Шүүгч П.Соёл-Эрдэнэ
11.	МУИС Хууль зүйн сургуульд 6.0 кредит хичээл зааж байгаа;	Шүүгч Ц.Цогт
12.	2023 оны 05 дугаар сарын 13-ны өдөр “Захиргааны хэргийн шүүхэд гаргах нэхэмжлэлийн шаардлагын төрөл, хэлбэр” сэдвийн хүрээнд хичээл заасан;	Шүүгч Ц.Цогт
13.	2023 оны 06 дугаар сарын 04-ний өдөр “Парламентын ардчиллыг бэхжүүлэхэд сэтгүүлчдийн оролцоо” сэдэвт хичээл заасан;	Шүүгч Ц.Цогт
14.	2023 оны 06 дугаар сарын 12-ны өдөр Архангай аймаг дахь шүүхийн шүүгч, ажилтнуудад “Шүүхийн стресс, түүнийг даван туулах арга замууд” сэдэвт хичээл орсон.	Шүүгч Ц.Цогт

15.	Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч нарт Шүүгчийн сургалтын хөтөлбөрт заасны дагуу сургалтыг явуулсан.	Шүүгч Ц.Цогт
16.	Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн болон Азийн сангийн хамтран зохион байгуулсан шинэ шүүгчийн сургалтад “Захиргааны эрх зүй дэх хууль тайлбарлан хэрэглэх онцлог” сэдэвт 4 цагийн сургалт орсон.	Шүүгч Г.Банзрагч
17.	ЗХШХШТХ-ийн 106 дугаар зүйлийн 106.3.11-ийн хэрэглээ, анхаарах асуудлууд сэдвээр Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч нарт хичээл заасан;	Шүүгч Г.Банзрагч
18.	Хуульчийн үргэлжилсэн сургалтын хүрээнд “Захиргааны хэргийн шүүхэд гаргах нэхэмжлэлийн төрөл, урьдчилсан нөхцөл” сэдэвт 1 багц цагийн МХХ-ны үндсэн лекц /видео хичээл/-ийг бэлтгэсэн. /2023 оны 11 сард/	Шүүгч Г.Банзрагч
19.	МХХ-ны Шалгалтын хорооноос зохион байгуулсан хуульчийн шалгалтад бэлтгэх сургалтад “Захиргааны эрх зүйн бодлого бодох аргачлал” сэдвээр нийт 3 удаа тус бүр 2 цагийн хичээл орсон.	Шүүгч Г.Банзрагч

Оролцсон хурал, зөвлөгөөн, уулзалт, хэлэлцүүлэг:

№	Хариуцан гүйцэтгэсэн ажил	Шүүгчийн нэр
1.	2023.12.08 Монгол Улсын дээд шүүхээс зохион байгуулсан “Шүүхийн практик судлал” хэлэлцүүлэг;	Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа
2.	2023 онд Сургалтын хөтөлбөрийн орон тооны бус хорооны 6 удаагийн хуралдаанд оролцсон;	Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа
3.	Шүүхийн ёс зүйн зөвлөх хорооны 4 удаагийн цахим хурал;	Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа
4.	МӨХ, Сэтгэл санааны хохирогчдын холбоо, МХХ-оос 2023.12.04-ны өдөр хамтран зохион байгуулсан хэлэлцүүлэгт УДШ-ийн баталсан “Хүний сэтгэгцэд учирсан хор уршгийг арилгах, нөхөн төлүүлэх төлбөрийн жишиг аргачлал”-ын талаар танилцуулга хийж, хэлэлцүүлэгт оролцсон.	Шүүгч Г.Банзрагч
5.	МХХ-ны Сургалтын хороо, УЕПГ-ын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэнгээс 2023.11.30-ны өдөр хамтран зохион байгуулсан “Хуульчдад зориулсан сургалтын тогтолцоо, шинэчлэл” сэдэвт хэлэлцүүлэгт панелистаар оролцсон.	Шүүгч Г.Банзрагч
6.	“Үндсэн хуулийн болон захиргааны эрх зүйн суурь асуудал” олон улсын эрдэм шинжилгээний IV бага хуралд оролцсон.	Шүүгч Ц.Цогт
7.	2023.03.29-ний өдрөөс 30-ны өдөр ТАІЕХ-ийн хүрээнд хэрэгжих үйл ажиллагааны талаар Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо болон Европын холбооны гишүүн 4 улсын (Австри, Эстони, Итали, Испани) холбогдох удирдах байгууллагууд хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулсан шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг бэхжүүлэх зорилгын хүрээнд шүүхийн захиргаа болон хэргийн хөдөлгөөний удирдлагад цахимжуулалтыг нэвтрүүлэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогч бүх байгууллагын цахимжуулалтын бодлого, хэрэгжүүлэлтийг уялдуулахад Европын улсуудын шүүхийн цахимжуулалтын туршлага судлах, техникийн туслалцааны үйл ажиллагаа хэрэгжүүлэх Европын холбооны экспертүүдийн уулзалт, ярилцлага;	Захиргааны хэргийн танхимын шүүгчид

8.	2023.04.04-ний өдөр мэдээлэл технологийн сургалт;	Захиргааны хэргийн танхимын шүүгчид
9.	2023 оны 05 дугаар сарын 26-ны өдөр “Дипломат ёслол” сэдэвт сургалтад тус тус оролцсон.	Захиргааны хэргийн танхимын шүүгчид
10.	2022.12.21-23-нд Орхон, Дархан-Уул аймагт ажиллаж, Орхон аймагт 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдөр Орхон аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх болон Булган аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчидтэй уулзаж Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 84, 85, 86 дугаар зүйлийн зарим заалтуудын албаны ёсны тайлбарын талаар мэдээлэл өгч, санал солилцож, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зөрүүтэй хэрэглээ, практикт тулгарч буй асуудлын талаар зөвлөлдсөн.	Захиргааны хэргийн танхимын шүүгчид
11.	2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн нийт шүүгчидтэй “Хуулийн тайлбар, хууль хэрэглээний нэгдмэл ойлголт” уулзалт ярилцлага;	Захиргааны хэргийн танхимын шүүгчид
12.	2023 оны 02 дугаар сарын 10-ны өдөр “Хуулийн тайлбар, хууль хэрэглээний нэгдмэл ойлголт” орон нутгийн захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчидтэй цахим уулзалт, ярилцлага;	Захиргааны хэргийн танхимын шүүгчид
13.	2023 оны 03 дугаар сарын 10-ны өдөр Улсын дээд шүүхийн Стратеги хөгжлийн төлөвлөгөөний төсөл боловсруулах уулзалт; 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдөр Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчидтэй Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл заалтыг тайлбарласантай холбогдуулан уулзалт;	Захиргааны хэргийн танхимын шүүгчид
14.	2023 оны 05 дугаар сарын 19-ний өдөр Чингэлтэй дүүргийн шүүх үүсэж байгуулагдсаны 30 жилийн ойн хүрээнд тус шүүхээс Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөлтэй хамтран зохион байгуулсан “Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тулгамдсан асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний бага хуралд тус тус оролцсон.	Захиргааны хэргийн танхимын шүүгчид
15.	2023.06.09-ний өдрийн бүсчилсэн уулзалтад (Архангай, Өвөрхангай, Баянхонгор аймгийн шүүхийн шүүгчидтэй хийсэн) оролцож, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд тулгамдаж буй асуудал болон Улсын дээд шүүхийн гаргасан хуулийн тайлбар дагасан сургалт явуулсан.	Шүүгч М.Батсуурь Шүүгч Д.Батбаатар Шүүгч Ц.Цогт
16.	2023.12.15-ны өдөр Монголын Хуульчдын холбооны Захиргааны эрх зүйн хорооны 10 жилийн ойд зориулсан “Захиргааны эрх зүй дэх Trajon Horse” сэдэвт хүндэтгэлийн лекц, хэлэлцүүлэг хийсэн.	Шүүгч Ц.Цогт

Ажлын хэсгийн оролцоо:

№	Хариуцан гүйцэтгэсэн ажил	Шүүгчийн нэр
1.	“Шүүхийн шийдвэрийг олон нийтэд мэдээлэх, арга зүйг тодорхойлох, мэдээллийн дэд бүтцийг оновчтой болгох, холбогдох журам баримт бичгийн төсөл боловсруулах” ажлын хэсгийн ахлагч;	Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа
2.	“Монгол Улсын дээд шүүхийн стратеги төлөвлөгөө боловсруулах” ажлын хэсгийн ахлагч;	Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа

3.	Захиргааны эрх зүйн чиглэлээр 2023 онд зохион байгуулах шүүгчийн сургалтын хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажлын хэсгийн ахлагч;	Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа
4.	Захиргааны хэргийн шүүхийн шүүгчдийн 2024 оны мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийн ахлагч;	Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа
5.	Шүүх эрх мэдэл хөгжлийн бичиг баримтыг боловсруулах ажлын хэсгийн гишүүн;	Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа
6.	Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн дэд ажлын хэсгийн гишүүн;	Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа
7.	Үндсэн хуулийн эрх зүй, Шүүгчийн ёс зүйн 2024 оны сургалтын ажлын хэсэгт гишүүн;	Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа
8.	Шүүхийн ёс зүйн зөвлөх хорооны гишүүн;	Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа
9.	“Монгол Улсын шүүхийн цахим систем” боловсруулж, нэвтрүүлэх ажлын хэсгийн ахлагч;	Шүүгч Д.Батбаатар
10.	“Хүний сэтгэцэд учирсан хор уршгийг арилгах, нөхөн төлүүлэх төлбөрийн жишиг аргачлалыг боловсруулах” ажлын хэсгийн гишүүн	Шүүгч Г.Банзрагч
11.	Нийт шүүгчийн чуулганы ажлын хэсгийн ахлагч;	Шүүгч М.Батсуурь
12.	“Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны дэг” болон “Улсын дээд шүүхийн Шүүгчдийн зөвлөгөөний дэг”-д нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүн;	Шүүгч М.Батсуурь
13.	“Шүүхийн цахим лавлагааны систем”-ийн төрлийг нэмэгдүүлэх, мэдээлэл солилцох журмыг боловсронгуй болгох чиг үүрэг бүхий ажлын хэсгийн гишүүн;	Шүүгч Х.Батсүрэн
14.	Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас “Давж заалдах шатны шүүх хуралдаанд бэлтгэх ажлын бүрдэл, хугацааны хуваарилалт, дарааллыг тогтоох, бэлтгэл хуралдаан хийх журмыг хэлэлцэж, батлах” журмын төслийг боловсруулах ажлын хэсгийн ахлагч;	Шүүгч Ц.Цогт
15.	УДШ-ийн тамгын газрын бүтэц орон тоог шинэчлэн боловсруулах ажлын хэсгийн ахлагч;	Шүүгч Ц.Цогт
16.	Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулах ажлын хэсгийн гишүүн;	Шүүгч Ц.Цогт
17.	Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн авсантай холбогдуулан Хууль зүйн байнгын хорооноос байгуулсан “Монгол Улсын шүүхийн тухай хуулийн зарим зүйл, хэсгийг боловсруулах” ажлын дэд хэсгийн гишүүн;	Шүүгч Ц.Цогт
18.	Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7.5.а, 25.7.5.б дэд заалтыг Үндсэн хуулийн цэц шийдвэрлэсэнтэй холбогдуулан Улсын дээд шүүхээс санал өгөх ажлын хэсэгт	Шүүгч Ц.Цогт
19.	“Монгол Улсын шүүхийн цахим систем” боловсруулж, нэвтрүүлэх ажлын хэсгийн гишүүн;	Шүүгч Ц.Цогт
20.	Шүүхийн шийдвэрийг олон нийтэд мэдээлэх ажлын хэсгийн гишүүн;	Шүүгч П.Соёл-Эрдэнэ
21.	Нотариатчидын Танхимын дэргэдэх Сахилгын зөвлөлийн ажиллах журмыг боловсруулах ажлын хэсгийн гишүүн;	Шүүгч П.Соёл-Эрдэнэ
22.	“Монгол Улсын шүүхийн цахим систем” боловсруулж, нэвтрүүлэх ажлын хэсгийн гишүүн	Шүүгч П.Соёл-Эрдэнэ

Контент бүтээх ажлын оролцоо:

№	Хариуцан гүйцэтгэсэн ажил	Шүүгчийн нэр
---	---------------------------	--------------

1.	“Шүүхийн шийдвэрийн хураангуй тойм бэлтгэх аргачлал” сэдэвт сургалтын видео контент /2023.05.10/	Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа
2.	“Ярьж буй хууль” нэвтрүүлэгт оролцсон /2023.07.29/	Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа
3.	Нийт шүүгчийн чуулганы талаар /Мэдээллийн хөтөлбөр 2023.09.28/	Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа
4.	“Улс төрийн намын бүртгэл” сэдвээр видео контент /2023.11.29/	Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа
5.	МҮОНТ-ийн 2023.10.09-ний өдрийн эрх зүйн хөтөч нэвтрүүлэгт Нийт шүүгчийн 2 дугаар чуулганы талаар ярилцлага өгч оролцсон.	Шүүгч М.Батсуурь
6.	“Шүүгчийн сахилга, хариуцлага” мэдээллийн хөтөлбөр бэлтгэсэн.	Шүүгч Ц.Цогт
7.	“Ял шийтгүүлсэн хүн ялаа эдэлсэн тохиолдолд магадлангаар суллагддаг, гэхдээ магадланг аль үед хэрэглэх вэ гэдгийг бодох хэрэгтэй” мэдээллийн хөтөлбөр бэлтгэсэн.	Шүүгч Ц.Цогт
8.	Шүүхийн бүтэц, зохион байгуулалт мэдээллийн хөтөлбөр бэлтгэсэн.	Шүүгч Ц.Цогт
9.	“Шударга шүүхээр шүүлгэх эрх” сэдвийн хүрээнд сурагчдад мэдээлэл хийсэн.	Шүүгч Ц.Цогт

Гадаад хурал, зөвлөгөөн, уулзалт, илтгэл, албан томилолт:

№	Хариуцан гүйцэтгэсэн ажил	Шүүгчийн нэр
1.	2023.02.01-ний өдөр Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо, Канад улсын холбооны шүүхийн комиссарын газраас хамтран зохион байгуулсан “Олон нийтийг мэдээллээр хангахад шүүгчдийн оролцоо, шүүхэд итгэх иргэдийн итгэлийг дээшлүүлэх арга замууд” сэдэвт хэлэлцүүлэгт “Шүүхийн шийдвэрийн тойм бичихэд үүсэж буй асуудлууд” сэдвээр илтгэл тавьсан;	Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа
2.	2023.02.02-ны өдөр Канад улсын төлөөлөгч нартай хийсэн уулзалт;	Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа
3.	2023.03.22-ны өдөр Монгол Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо, Канад улсын холбооны шүүхийн комиссарын алба, Канадын олон улсын байгууллага, Европын холбоотой хамтран зохион байгуулсан “Хууль дээдлэх ёсыг бэхжүүлэх ба олон нийтийн шүүхэд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх нь” сэдэвт ОУ-ын бага хуралд илтгэл тавьсан;	Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа
4.	2023.03.29-ний өдөр Европын холбооны зөвлөхүүдтэй хийсэн уулзалт;	Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа
5.	Европын Холбооны Техникийн туслалцаа, мэдээлэл солилцох хөтөлбөрийн хүрээнд ажилласан Итали Улсын шүүгч Мариа Жулиана Сивинини, Австри Улсын шүүгч Гернот Пош тэргүүтэй төлөөлөгчдийг 2023 оны 3 дугаар сарын 29-ний өдөр хүлээн авч, хамтын ажиллагааны талаар хийсэн уулзалт;	Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа
6.	Ханнс-Зайделийн сангийн Ерөнхий нарийн бичгийн дарга Оливер Йёрг болон түүний төлөөлөгчдийг 2023 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр хүлээн авч уулзаж, хамтын ажиллагааны талаар хийсэн уулзалт;	Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа
7.	Европын Аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Ардчилсан институт хүний эрхийн албаны дарга Маттео Меккаччи болон түүний төлөөлөгчдийг 2023	Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа

	оны 11 дүгээр сарын 17-ны өдөр хүлээн авч уулзаж, хамтын ажиллагааны талаар хийсэн уулзалт;	
8.	Канад улсад 2023.11.24-ний өдрөөс 12.05-ны өдөр албан томилолт;	Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа
9.	Холбооны Бүгд Найрамдах Герман улсад 2023.06.18-ны өдрөөс 25-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “ХБНГУ-д судалгааны айлчлал”-д оролцож, мэдээлэл солилцсон.	Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа Шүүгч Г.Банзрагч Шүүгч Д.Батбаатар Шүүгч Ц.Цогт
10.	Швейцарын Холбооны Улсын Женев хотноо 2023 оны 11 дүгээр сарын 15-16-ны өдрүүдэд болж буй “Оюуны өмчийн асуудлаарх Шүүгчдийн форум”-д оролцож Дэлхийн оюуны өмчийн байгууллага (ДОӨБ)-ын Шүүхийн хүрээлэнг хариуцсан орлогч захирал Марко Алемантай уулзалт хийж, Шүүхийн сургалт, судалгаа мэдээллийн хүрээлэн болон тус байгууллага хоорондын хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурах ажиллагаанд оролцсон.	Шүүгч Д.Батбаатар
11.	БНСУ-ын Шүүхийн сургалт, судалгааны хүрээлэнгийн урилгаар 2023.04.24-28-ны өдрүүдэд тус улсын Сөүл хотноо “БНСУ-ын шүүхийн цахимжилт” сэдэвт сургалт;	Шүүгч Д.Батбаатар Шүүгч Г.Банзрагч
12.	Тайландын Бангкок хот дахь International Law Enforcement Academy (ILEA) -д 2023 оны 03 дугаар сарын 13-ны өдрөөс 17-ны хооронд зохион байгуулагдах Цахим нотлох баримт сэдэвт шүүгч, прокуроруудад зориулсан олон улсын сургалтад оролцсон.	Шүүгч М.Батсуурь
13.	Швейцарын Холбооны Улсын Женев хотноо 2023 оны 11 дүгээр сарын 15-16-ны өдрүүдэд болж буй “Оюуны өмчийн асуудлаарх Шүүгчдийн форум”-д оролцож Дэлхийн оюуны өмчийн байгууллага (ДОӨБ)-ын Шүүхийн хүрээлэнг хариуцсан орлогч захирал Марко Алемантай уулзалт хийж, Шүүхийн сургалт, судалгаа мэдээллийн хүрээлэн болон тус байгууллага хоорондын хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурах ажиллагаанд оролцсон.	Шүүгч М.Батсуурь
14.	Бүгд Найрамдах Турк улс (БНТУ)-ын Шүүхийн академийн урилгаар 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр тус улсын дээд шүүх, Шүүхийн академид зочилж, Дээд шүүхийн шүүгч бөгөөд Хэрэг эрхлэх газрын дарга Февзи Илдирим, Дээд шүүхийн шүүгч бөгөөд Хэрэг эрхлэх газрын дэд дарга Мустафа Салдирим, Шүүхийн академийн Гадаад харилцааны газрын дарга Хасан Кадир Илмазтекин нартай уулзаж, хамтын ажиллагааны талаар хийсэн уулзалт;	Шүүгч Д.Батбаатар Шүүгч М.Батсуурь
15.	БНТУ-ын Шүүхийн академийн ерөнхийлөгч Мухиттин Өздемир, Гадаад харилцааны газрын дарга Хасан Кадир Илмазтекин нартай уулзаж, шүүгчдийн сургалтын чиглэлээр хамтран ажиллах талаар санал солилцох айлчлалд оролцсон;	Шүүгч Д.Батбаатар Шүүгч М.Батсуурь
16.	Европын Холбооноос Монгол Улсад суугаа Төлөөлөгчийн газрын Хамтын ажиллагааны хэлтсийн дарга Адриен Мүрг, ажилтан Евгения Фараза нартай 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр хамтын ажиллагааны асуудлаар уулзалт хийсэн.	Шүүгч Ц.Цогт
17.	АНУ-ын Үндэсний шүүхүүдийн төвийн захирал Дэвид Сакар тэргүүтэй төлөөлөгчдийг 2023 оны 05 дугаар сарын 19-ны өдөр хүлээн авч, хамтын ажиллагааны талаарх уулзалт хийсэн.	Шүүгч Ц.Цогт
18.	Шүүгч, хуульчдын хараат бус байдлын асуудал хариуцсан Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын тусгай илтгэгч	Шүүгч Ц.Цогт

	Маргарет Саттертуэйт тэргүүтэй төлөөлөгчдийг 2023 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр хүлээн авч уулзсан.	
19.	Бангкок дахь Европын Холбооны Төлөөлөгчийн газрын Хамтын ажиллагааны хэлтсийн дарга Даниел Хачез болон Улаанбаатар дахь Европын Холбооны Төлөөлөгчийн газрын Хамтын ажиллагааны хэлтсийн хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн Апприоу Арно Пиерре нарыг 2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр хүлээн авч хамтын ажиллагааны асуудлаар уулзалт хийсэн байна.	Шүүгч Ц.Цогт
20.	Монгол Улс дахь АНУ-ын Элчин сайдын яамтай хамтран шүүгчдэд зориулсан “Оюуны Өмчийн Эрхийн хэрэгжилт” сэдэвт 2023 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр зохион байгуулсан сургалтад оролцсон.	Шүүгч Ц.Цогт
21.	Олон улсын эрүүгийн шүүхээс Бүгд Найрамдах Солонгос Улсын Сөүл хотод 2023.11.13-наас 16-ны өдрүүдэд зохион байгуулсан “Олон улсын эрүүгийн шүүх ба Ази-Номхон далай: Ромын дүрмийн өнгөрсөн, одоо, ирээдүй – бүс нутгийн нэгдмэл байдлын төлөөх алсын хараа” сэдэвт өндөр түвшний зөвлөгөөнд оролцсон.	Шүүгч Ц.Цогт
22.	2023 оны 11 дүгээр сарын 29-нөөс 12 дугаар сарын 8-ны хооронд Олон улсын эрүүгийн шүүхээс Америкийн Нэгдсэн Улсын Нью-Йорк хотод зохион байгуулсан Ромын дүрмийн Оролцогч улсуудын холбооны 22 дахь удаагийн хуралд оролцсон.	Шүүгч Ц.Цогт

Бичсэн ном, гарын авлага:

№	Хариуцан гүйцэтгэсэн ажил	Шүүгчийн нэр
1.	Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгээс эрхлэн гаргадаг “Монголын төр, эрх зүй” сэтгүүлд 3 эрдэм шинжилгээний өгүүлэлд шүүмж бичсэн.	Шүүгч Г.Банзрагч
2.	Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгээс эрхлэн гаргадаг “ “Монголын төр, эрх зүй” сэтгүүлд 1 өгүүлэл хянан магадалсан, мөн Хууль зүйн Үндэсний Хүрээлэнгийн “Хууль дээдлэх ёс” сэтгүүлд 3 өгүүлэлд хянан магадалгаа хийсэн. /Редакцын зөвлөлийн гишүүний хувьд/	Шүүгч Г.Банзрагч
3.	Хууль зүйн Үндэсний Хүрээлэнгийн “Хууль дээдлэх ёс” сэтгүүлд 5 эрдэм шинжилгээний өгүүлэлд шүүмж бичсэн. /нийт 8 эрдэм шинжилгээний шүүмж/	Шүүгч Г.Банзрагч
4.	Захиргааны процессын эрх зүй сурах бичгийн 2 дахь хэвлэлт.	Шүүгч Г.Банзрагч
5.	“Монгол Улс дахь хуулийн тайлбар: Абстракт аргачлалаас чөлөөлөгдөх нь” сэдэвт бүтээл хэвлүүлсэн.	Шүүгч Ц.Цогт
6.	“Үндсэн хууль манай сургуульд” НҮБ-ын Хүний эрхийн хороодын ерөнхий тайлбар болон сургалтын хөтөлбөр боловсруулсан (судлаач нарын хамт)	Шүүгч Ц.Цогт

3.ЕРӨНХИЙ ШҮҮГЧИЙН АЖЛЫН АЛБА

Монгол Улсын шүүхийн тухай хууль (Шинэчилсэн найруулга)-д Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаан, Шүүгчдийн зөвлөгөөнөөр хэлэлцэх асуудлыг тусгайлан зохицуулсан бөгөөд хуралдааныг тасралтгүй, хэвийн явуулах

ажлыг зохион байгуулалтаар ханган хэрэгжүүлэх чиг үүргийг Тамгын газрын дэмжлэгтэйгээр Ерөнхий шүүгчийн Ажлын алба хариуцан ажиллаж байна.

2023 онд Нийт шүүгчийн хуралдаан 13 удаа товлогдож, 75 асуудлыг, Шүүгчдийн зөвлөгөөн 7 удаа товлогдож, 13 асуудлыг тус тус хэлэлцэн шийдвэрлэсний дотор хууль тайлбарласан 9 тогтоол (Хүснэгт 1), хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд холбогдох журам, аргачлалуудыг (Хүснэгт 2) хэлэлцэн баталжээ.

Хуулийг зөв хэрэглэх талаар Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас гаргасан албан ёсны тайлбарууд

Хүснэгт 1

№	Тогтоолын нэр	Тогтоолын он, сар, өдөр	Дугаар
1.	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 10.1, 10.2, 10.3, 10.4 дүгээр зүйлийн зарим хэсэг, заалтыг тайлбарлах тухай	2023.01.12	04
2.	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 84, 91, 92 дугаар зүйлийн зарим хэсэг, заалтыг тайлбарлах тухай	2023.01.12	05
3.	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн Арван зургаадугаар бүлгийн зарим зүйл, хэсэг(§16.3, §16.5)-ийг зөв хэрэглэх албан ёсны тайлбар	2023.04.14	16
4.	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 38, 120, 124, 166, 167 дугаар зүйлийн зарим заалтыг тайлбарлах тухай	2023.04.14	17
5.	Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим заалтыг тайлбарлах тухай	2023.04.14	18
6.	Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.8, 36.9 дэх хэсгийг тайлбарлах тухай	2023.04.14	19
7.	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.15 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг тайлбарлах тухай	2023.05.08	24
8.	Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим заалтыг тайлбарлах тухай	2023.07.03	30
9.	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөв хэрэглэх албан ёсны тайлбар	2023.07.03	31

Монгол Улсын дээд шүүхийн Шүүгчдийн зөвлөгөөнөөр баталсан журам, аргачлалын жагсаалт

Хүснэгт 2

№	Журмын нэр	Журмын он, сар, өдөр	Дугаар
1.	“Эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх шүүх хуралдааны дэг, журам”-ыг 1 дүгээр хавсралтаар, “Хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэр боловсруулах журам, аргачлал”-ыг 2 дугаар хавсралтаар, “Шүүгдэгчид шүүх хуралдааны дэг болон эрх, үүрэг танилцуулсан баримт”-ыг 3 дугаар хавсралтаар, “Хохирогчид шүүх хуралдааны дэг болон эрх, үүрэг танилцуулсан баримт”-ыг 4 дүгээр хавсралт	2023.03.20	13
2.	Хүний сэтгэц учирсан хор уршгийг арилгах, нөхөн төлүүлэх төлбөрийн жишиг аргачлал	2023.07.03	25

Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, хүсэлт болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авч хуульд заасны дагуу хариу өгч шийдвэрлэн ажиллажээ.

Хуульд заасны дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны болон шүүхийн удирдлага зохион байгуулалттай холбогдуулан гаргасан Ерөнхий шүүгчийн захирамжийн албан ёсны хүчин төгөлдөр байдлыг хангуулан ажилласан байна.

Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч төсвийн ерөнхийлөн захирагчийн ажлын хүрээнд байгууллагын бодлого төлөвлөлт, стратегийн зорилт, гүйцэтгэлийн төлөвлөгөөг ханган биелүүлэхэд шүүхийн төсөв, санхүүгийн үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэн зохион байгуулах чиг үүргийн хүрээнд хуульд заасан хугацаанд тайланг Үндэсний аудитын газарт хүргүүлж “Зөрчилгүй” санал дүгнэлт авч, 2024 оны төсвийн төслийг боловсруулан холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.

№	Ерөнхий шүүгчийн оролцсон уулзалт, хэлэлцээрүүд:
1	2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр Бүгд Найрамдах Казахстан Улсаас Монгол Улсад суух Элчин сайд Габит Койшибаев, зөвлөх Сабит Негметжанов нарыг хүлээн авч уулзсан;
2	2023 оны 05 дугаар сарын 24-ний өдөр Бүгд Найрамдах Киргиз Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчтэй цахим уулзалт хийсэн;
3	2023 оны 06 дугаар сарын 30-ны өдөр БНСУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд Ким Жун Гүг хүлээн авч уулзсан;
4	2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр Ханнс-Зайделийн сангийн Ерөнхий нарийн бичгийн дарга Оливер Иёрг, тус сангийн Төв болон Зүүн хойд Ази дахь төсөл хариуцсан хэлтсийн дарга Вероника Айхинга, Монгол дахь төлөөлөгчийн газрын тэргүүн Феликс Ионатан Гленк нарыг хүлээн авч уулзсан;
5	2023 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр Шүүгч, хуульчдын хараат бус байдлын асуудал хариуцсан Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын тусгай илтгэгч Маргарет Саттертуэйт тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзсан;

4.МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР

Тамгын газар нь Улсын дээд шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, шүүгч, шүүх бүрэлдэхүүнээс хэрэг, маргааныг шийдвэрлэхэд мэдээлэл, судалгаа, санхүү, аж ахуй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэн, ажиллах нөхцөлөөр хангах үндсэн чиг үүргийн хүрээнд Төсвийн ерөнхийлөн захирагчаар гүйцэтгэлийн төлөвлөгөө батлуулан ажиллав.

4.1.ЗАХИРГАА, ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГА

Монгол Улсын шүүхийн тухай хууль 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс шинэчлэгдэн батлагдаж шүүх эрх мэдлийн салбарт, ялангуяа Монгол Улсын дээд шүүхийн үйл ажиллагаанд томоохон өөрчлөлт, шинэчлэлийг авч ирсэн бөгөөд хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг нэмэгдүүлэх, нийгмийн хөгжлийн шаардлагад нийцүүлж ажиллахад шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах, орчин үеийн мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлэх, шүүхийн захиргааны хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах зорилтуудыг тавин ажиллаж байна.

Энэ ажлын хүрээнд “Монгол Улсын дээд шүүхийн 2023-2026 оны стратеги төлөвлөгөө”-ний төслийг 4 зорилт 69 арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэхээр боловсруулж, хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

ИРГЭН ТӨВТЭЙ ШҮҮХ ТОГТОЛЦОО ТӨЛӨВШИНӨ.

“Алсын хараа 2050”




Хүлээн авсан албан бичиг, өргөдөл, гомдол, явуулсан бичиг:

Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газраас 2023 онд утсаар болон өөрийн биеэр ирж үйлчлүүлсэн 5476 иргэн, хуулийн этгээдэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой мэдээлэл, лавлагаа өгсөн. Мөн байгууллагын QR код уншуулан тус шүүхийн цахим хуудаснаас холбогдох мэдээ мэдээллээ бүрэн авах боломжтой тухай иргэд, хуулийн этгээдэд мэдээлэл хүргэн ажиллаж байна.

Тайлан хугацаанд Тамгын газарт 342 өргөдөл гомдол, 911 албан бичиг хүлээн авч, зохих журмын дагуу бүртгэн, бүртгэл хяналтын карт нээж, эрх бүхий албан тушаалтанд танилцуулсны дагуу холбогдох шүүгч, ажилтнуудад тухай бүр шилжүүлэн өгч шийдвэрлүүлснээс гадна 3955 албан бичигт дугаар өгч холбогдох шүүх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хүргүүлжээ.

2023 онд хүлээн авсан хэрэг, албан бичиг, өргөдөл гомдлыг 2022 онтой харьцуулсан үзүүлэлт:



Шүүгчийн хараат бус байдлыг хангах чиглэлээр:

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2021 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 49 дүгээр тогтоолоор баталсан “Нөлөөллийн мэдүүлэг хөтлөх, тэмдэглэл үйлдэх, шийдвэрлэх журам”-ыг мөрдлөг болгон шүүгчийн хараат бус байдлыг хангах, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах талаар зохих арга хэмжээг авч ажилласан бөгөөд бүтэн жилийн хугацаанд нөлөөллийн мэдүүлэг хөтөлсөн шүүгч байхгүй байна.

Холбогдох хууль, тогтоомжид заасан журмын дагуу цахим хуудсанд нээлттэй сонгон шалгаруулалт зарлаж, хуульд заасан журмаар баримт бичгийн шаардлага хангасан оролцогчидтой “Шүүгчийн амь нас, эрүүл мэндийн даатгал”-ын гэрээ, “Эрүүл мэндийн даатгал”-ын гэрээг тус тус байгуулан, даатгалын гэрээний талаарх сургалтад хамруулсан. Гэрээний хэрэгжилтийн хүрээнд давхардсан тоогоор 26 шүүгчийн даатгалын тохиолдлын нөхөн төлбөрийг гаргуулсан.




Мөн шүүгчийн амь нас, эрүүл мэндийн даатгалын тохиолдлын тоог 34 байсныг 38 болгож нэмэгдүүлсэн байна. Шүүгчийн нийгмийн баталгааг хангах зорилгоор Тамгын газрын даргын 2023 оны А/56 дугаар тушаалаар Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2023 оны 207 дугаар тогтоолоор баталсан “Шүүгчийн ажлын ачаалал тооцох шалгуур үзүүлэлт, шүүгчид нэмэгдэл урамшуулал олгох журам”-ыг үндэслэн 21 шүүгчид урамшуулал олгосон.

Цагаатгалын ажлын чиглэлээр:

Монгол Улсын дээд шүүхэд тайлант хугацаанд Улсын Ерөнхий Прокурорын газраас прокурорын дүгнэлт бичиж ирүүлсэн цагаатгалын 8 хэрэг хүлээн авч, үүнээс 27 хэлмэгдэгчид холбогдох 8 хэргийг хэрэгсэхгүй болгон цагаатгаж шийдвэрлэсэн.

Энэ хугацаанд Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийн цагаатгалын үнэмлэх олгох талаар хэлмэгдэгчдийн төрөл садан болон Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах салбар комиссуудаар дамжуулан нийт 12 өргөдөл, хүсэлтийг хүлээн авч, үүнээс 6 цагаатгалын үнэмлэх (шинээр-6 үнэмлэх, нөхөн-0 үнэмлэх) олгож, 6 өргөдөл, хүсэлтэд зохих журмын дагуу хариу өгсөн байна.



Хүний нөөцийн чиглэлээр:

Төрийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан, үнэлгээг холбогдох журмын дагуу үнэлэн, гүйцэтгэлийн үр дүнг үндэслэн 2023 онд 211 төрийн албан хаагчид үр дүнгийн урамшуулал олгосон.



Сонгон шалгаруулах журам, албан тушаалд тавигдах шаардлагын дагуу 8 албан тушаалыг сонгон шалгаруулалтаар, 10 албан тушаалыг төрийн бусад байгууллагаас шилжүүлэн, төрийн үйлчилгээний 7 ажлын байр, нийт 25 сул орон тоог холбогдох хууль журмын дагуу нөхсөн байна.

“Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системд холбогдох журмын дагуу хөтлөн явуулж байгаа бөгөөд шүүгч, ажилтнуудын албан тушаалын шилжилт хөдөлгөөн, цалингийн шатлал, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл болон бусад өөрчлөгдөж буй мэдээллийг тухай бүрт нь шинэчилсэн.

2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр “Шинэ ажилтны дасан зохицох дэд хөтөлбөр”-ийг боловсруулж батлуулсан бөгөөд хэрэгжилтийг ханган ажиллах хүрээнд Тамгын газарт 2023 онд томилогдсон 22 албан хаагчийг тус хөтөлбөрт хамруулжээ.

Тамгын газрын ажилтнуудаас хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтнуудад хөрөнгө орлогын мэдүүлгээ хуульд заасны дагуу мэдүүлэхэд нь дэмжлэг үзүүлж, хөрөнгө орлогын мэдүүлгийг тухай бүр нь бүртгэх, хадгалах арга хэмжээг зохих журмын дагуу хэрэгжүүлж 2023 онд 43 албан хаагчийн хөрөнгө орлогын мэдүүлэг болон их хэмжээний өөрчлөлтийн мэдүүлэг, албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн 7 хүний хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг гаргуулж, баталгааны хуудсыг зохих журмын дагуу хадгалж, тайланг Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн байна.


2023 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар 2 шүүгч томилогдсон, 1 шүүгч өндөр насны тэтгэвэрт гарсан.

Хяналтын шатны шүүх бүрэлдэхүүний тоон мэдээллийг нэгтгэн харвал:




Хяналтын шатны шүүхийн хэвийн тасралтгүй байдлыг ханган ажиллахад хүний нөөцийн чадавх, тэдгээрийн тогтвортой байдал чухал үүрэгтэй. Тамгын газрын хүний нөөцийн тоон мэдээллийг нэгтгэн харвал:

БОЛОВСРОЛ




■ БАКАЛАВР ■ МАГИСТР
■ ТУСГАЙ ДУНД ■ ДОКТОРАНТ
■ ДОКТОР

МЭРГЭЖИЛ




АЛБАН ХААГЧДЫН ХҮЙСИЙН ХАРЬЦАА



Төрийн захиргааны



Төрийн захиргаа Төрийн үйлчилгээ



■ 21-25 нас ■ 26-30 нас ■ 31-35 нас
■ 36-40 нас ■ 41-45 нас ■ 46-50 нас
■ 51-55 нас ■ 56-60 нас ■ 61-аас дээш



Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах хүрээнд:



Албан хаагчдын сургалт, хөгжлийн чиглэлээр:

2023 оны Сургалтын төлөвлөгөөний дагуу танхимаар 44 удаа, цахимаар 21 удаа сургалтуудыг тус тус зохион байгуулсан байна.

ЦАХИМ СУРГАЛТЫН ПЛАТФОРМ АШИГЛАЖ ЭХЭЛСЭН

ТАНХИМЫН СУРГАЛТ

44

ЦАХИМ СУРГАЛТ

21

Тамгын газрын 2022-2024 оны сургалтын хөтөлбөрийн хүрээнд Зангиа академийн сургалтын платформыг ашиглаж эхэлсэн. Тайлант хугацаанд тус платформын дотоодын сургалт цэсэнд мэргэжил, хувь хүний ур чадвар, монгол бахархал сэдвээр 21 цахим хичээл байршуулаад байна. Мөн Зангиа академийн сургалтаас албан хаагчдын өгсөн саналыг үндэслэн хэрэглээний программын 12 сургалтуудыг хуваарилсан.

Хууль зүйн судалгааны арга зүйн багц сургалтыг зохион байгуулж, судлаач, шинжээчид бүрэн хамрагдсан. Сургалтаар хууль зүйн судалгааны аргачлал, эх сурвалжийн системийн шинжилгээний арга зүй, судалгааны дизайн боловсруулах, судалгааны ажлын нийтлэг шаардлага ба практик судалгааны онцлог зэрэг сэдвүүдийг хамарсан.

Мөн шүүгчийн судлаач-туслахуудад зориулсан SPSS программын сургалтад судлаач, шинжээчид хамрагдаж батламж авсан.

Хамт олныг хөгжүүлэх, эерэг хандлага түгээх зорилгоор Монгол Улсын дээд шүүхийн Ахмадын зөвлөлийн гишүүдийг хүлээн авч хүндэтгэл үзүүлэх, “Ахмадаасаа суралцъя” гурван үеийн уулзалт зохион байгуулсан. болон “Монгол бахархал, төрт ёс ба хууль эрх зүйн түүхэн уламжлал” сэдэвт хөтөлбөр боловсруулан энэ хүрээнд Чингис хаан үндэсний музей, Монгол банкны дэргэдэх Эрдэнэсийн сантай танилцах ажлыг зохион байгуулсан.

Төрийн захиргааны албан тушаалд тавигдах тусгай шаардлагын хүрээнд Удирдлагын академийн мэргэшүүлэх сургалтад Төрийн захиргааны албан тушаалын тэргүүн түшмэлийн ангилалд 2, Эрхэлсэн түшмэлийн ангилалд 2 албан хаагч, Ахлах түшмэлийн ангилалд 3 албан хаагч, төрийн албаны анхан шат, дунд шатны мэргэшүүлэх багцад 3 нийт 10 албан албан хаагч хамрагдсан байна.

Архив, номын сангийн чиглэлээр:

Архивын сан хөмрөгийн бүрдүүлэлтийг батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж, байнга хадгалах 184, түр хадгалах 120, 70 жил хадгалах 6, нийт 310 хадгаламжийн нэгж хүлээн авч, тайлангийн хугацаанд 114 хүнд 190 удаа /давхардсан тоо/, 1450 хуудас баримтыг хуулбарлан лавлагааг гарган өгч ажилласан байна.

АРХИВЫН БАРИМТЫГ ЦАХИМ ХЭЛБЭРТ ШИЛЖҮҮЛЭХ АЖЛЫГ ЭХЛҮҮЛСЭН.

Байнга хадгалах архивын баримтуудыг цахимжуулах ажлын хүрээнд өнөөдрийн байдлаар 1996-2022 оны Монгол Улсын дээд шүүхийн тогтоол, тэмдэглэл, Эрүү, Иргэн, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал, Хяналтын шатны Эрүү, Иргэн, Захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоол, Ерөнхий шүүгчийн захирамж, Нийт шүүгчдийн хуралдааны тогтоол, тэмдэглэл, Монгол Улсын дээд шүүхийн шүүгчдийн зөвлөгөөний тогтоол, тэмдэглэл, Тамгын газрын даргын тушаал зэрэг 1487 хадгаламжийн нэгж бүхий 308218 хуудас архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлж, архивын цахимжилтын ажил бүрэн дууссан.

1487

**ХАДГАЛАМЖИЙН
НЭГЖ БҮХИЙ**


308218

**ХУУДАС АРХИВЫН
БАРИМТЫГ ЦАХИМ
ХЭЛБЭРТ**




Номын фондыг баяжуулах, эргэлтийг сайжруулах зорилгоор Монгол Улсын дээд шүүхийн шүүгчид болон бүтцийн нэгжүүдээс 32 нэр төрлийн 306 ном, хэвлэлийн захиалгыг авч нэгтгэн удирдлагад танилцуулж, тайлангийн хугацаанд 39 нэр төрлийн 197 ном, гарын авлага худалдан авсан.

Номын санд цахим хайлтын Коха системийг нэвтрүүлж, номын фонд дахь 6272 номыг цахим каталогид хөрвүүлэн хэрэглээнд нэвтрүүлсэн байна.



Техник, программ хангамжийн чиглэлээр:

Олон улсын эрүүгийн шүүхийн шүүгчид нэр дэвшиж буй Д.Эрдэнэбалсүрэн шүүгчийн нэр дэвшигчийн танилцуулга веб сайтын загварыг гаргаж Бодь электроникс компаниар гүйцэтгүүлж erdenebalsuren.supremecourt.mn нэртэйгээр сайтын дэд хуудас болгон байршуулав.



Монгол Улсын дээд шүүхийн байр, Хангарди ордон, Шүүхийн ерөнхий зөвлөлийн сүлжээний холболтын тохиргоог Мобинет ХХК болон Юнивишн ХХК-тай холбогдож хийснээр Хангарди ордноос Монгол Улсын дээд шүүхийн байрны дотоод сүлжээнд мөн Шүүхийн ерөнхий зөвлөлийн байран дахь хэргийн хөдөлгөөний системүүдэд хандах боломж бүрдсэн.

Их танхим дахь шүүх хуралдааны дуу, дүрс бичлэгийн Panasonic /2013/ төхөөрөмжийг өндөр нягтаршил бүхий Hikvision төхөөрөмжөөр сольж, автоматаар



төхөөрөмжийг зөвхөн Монгол Улсын дээд шүүхээр тогтохгүй анхан болон давж заалдах шатны шүүхүүдийн хэрэгцээ шаардлыг нарийвчлан тодорхойлж гаргасан.

Энэ хүрээнд техникийн нөхцөл, төсвийн тооцоо, хэрэгжилтийн төлөвлөгөө, зөвлөмж зэрэг тоног төхөөрөмжийн шаардлагыг нарийвчлан тусгасан иж бүрэн тайлан гаргасан бөгөөд төсөл хэрэгжсэнээр Монгол Улсын шүүхийн тогтолцоог шинэчлэх, цахим хэлбэрт шилжүүлэхэд цахим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг амжилттай хэрэгжүүлэх замын зураглал болох юм.

4.2.ХЭРГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ УДИРДЛАГА


Цахим шүүх хуралдааны бэлтгэл хангах, шүүх хуралдааны явцыг дууны, дуу-дүрсний бичлэгээр баталгаажуулах, шүүн таслах ажиллагааны улирал, хагас, бүтэн жилийн тайлан мэдээ гарган холбогдох байгууллагад хүргүүлэх, хуульд заасан бусад чиг үүргийг гүйцэтгэхийн зэрэгцээ бүртгэл хяналтын нэгдсэн систем хөтлөлтийн явцад хяналт тавин ажиллаж байна.

Тайлангийн хугацаанд эрүүгийн 892, иргэний 1460, захиргааны 523, сахилгын 9 хэрэг, нийт 2884 хэргийг хүлээн авч, бүртгэлийн хуудаст бүртгэн, Танхимын тэргүүний туслах, шүүгчид хүлээлгэн өгч, 2056 хэргийг холбогдох шүүхүүдэд илгээсэн байна.

Шүүхийн цахим хуудас (www.supremecourt.mn)-т хяналтын шатны шүүх хуралдааны эрүүгийн 186, иргэний 304, захиргааны 149, сахилгын 17 нийт 656, танхимын нийт шүүгчийн хуралдааны эрүүгийн 901, иргэний 1456, захиргааны 501 нийт 2858 зар, тоймыг цахим хуудсаар тус тус олон нийтэд мэдээлжээ.

Шүүх хуралдааны явцыг (<http://live.shuukh.mn>) цахимаар мэдээлж, шүүх хуралдааны явцыг хөтөлж, дууны, дуу-дүрсний бичлэгээр баталгаажуулсан.

Мөн хугацаанд хяналтын шатны 607 шүүх хуралдаанд танхимаар 1620, цахимаар 205 хэргийн оролцогч оролцсон байна.



Бүртгэл хяналтын нэгдсэн системд эрүү, иргэн, захиргааны хэргийн шүүх хуралдааны тэмдэглэл 607, шүүхийн тогтоол 128, шүүгчийн захирамж 58, хяналтын шатны шүүх хуралдааны тогтоол 508, нийт 1301 бүртгэл тус тус хөтлөгдсөн.

Хяналтын шатны шүүх хуралдаанаар шийдвэрлэгдсэн 508 хэргээс цахим санд байршигдвал зохих эрүүгийн 147, иргэний 227, захиргааны 90, нийт 464 тогтоол байршигдсан. Сахилгын хэргийн систем хөгжүүлэлтийн шатандаа явагдаж байна.

Цахим сан (www.shuukh.mn, supremecourt.mn)-д хяналтын шатны шүүх хуралдааны тогтоол нөхөн байршуулалтын ажил 100% гүйцэтгэсэн.

Хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдааны шийдвэрээр гарсан 91 мэдэгдэх хуудсыг холбогдох байгууллагад хугацаанд нь хүргүүлсэн.

Хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар маш нууц 3, иргэний хэргийн шүүх хуралдаанаар маш нууц 1, захиргааны хэргийн шүүх хуралдаанаар маш нууц 1 хэрэг тус тус хэлэлцэгдсэн.

Улс төрийн намын бүртгэл хөтлөх журамд заасны дагуу 61 өргөдөл, албан бичиг 24, нийт 85 өргөдөл, албан бичиг хүлээн авч, УДШ-ийн нийт шүүгчийн хуралдаанаар 17 өргөдлийг хэлэлцүүлж, танхимын нийт шүүгчийн хуралдаанаар 44 өргөдөл, 24 албан бичгийг хэлэлцэн буцаасан байна.

Улсын дээд шүүхийн цахим хуудсанд “Улс төрийн намын бүртгэл” хэсэгт 37 намын мэдээллийг шинэчлэн оруулсан.



Тайлангийн хугацаанд тус хэлтэс албан бичиг 80, өргөдөл, гомдол, хүсэлт 79-ыг тус тус зохих журмын дагуу хүлээн авч, судлан холбогдох албан тушаалтанд танилцуулан хуулийн хугацаанд хариуг уламжилсан байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн Хэргийн хөдөлгөөний удирдлагын хэлтсээс “Хэргийн хөдөлгөөний нэгдсэн систем ашиглах журам” хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүртгэл, хяналтын нэгдсэн систем ашиглалт, цахимаар шүүх хуралдааныг зохион байгуулах, мэдлэг чадварыг дээшлүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулсан.

4.3. ШҮҮХИЙН ПРАКТИК СУДЛАЛ

Хяналтын шатны шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх, шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлэх ба хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахад шаардлагатай судалгаа, мэдээллээр хангах ажлыг удирдан зохион байгуулах, чанарыг сайжруулах зорилгын хүрээнд:

- Шүүхийн шийдвэрийн судалгааны;
- Төсөөтэй тогтоолын судалгааны;
- Тойм судалгааны;

- Насжилтын судалгааны 4 загварыг (дизайн) Шүүхийн практик судалгааны багц зааврын хүрээнд боловсруулж, хавсралтаар батлуулсан байна.

Тайлант хугацаанд эрүүгийн хэргийн чиглэлээр 35 иргэний хэргийн чиглэлээр 18, захиргааны хэргийн чиглэлээр 34, нийт 87 судалгааны ажлыг хийж гүйцэтгэн, холбогдох захиалагчид хүргүүлэв.

Хяналтын шатны шүүхээр тухайн онд шийдвэрлэсэн эрүү, иргэн, захиргааны хэргийн тойм судалгааг гаргасан ба цаашид улам боловсронгуй тайлан гаргах, секторууд нийтлэг стандарттай байхад “Шүүхийн практик судалгааны нийтлэг заавар”-ыг боловсруулж батлуулсан нь ач холбогдолтой байлаа.

Хэргийн хөдөлгөөний удирдлагыг хэрэгжүүлэх, хэрэг хянан шийдвэрлэх дундаж хугацаа, үзүүлэлт, ажиллагаанд байгаа хэргийн насжилт, тодорхой хэргийн хөдөлгөөний хугацааны талаарх судалгааг хагас, бүтэн жилээр хийж гүйцэтгэсэн.

Шүүгчийг хууль тогтоомж, судалгаа, гарын авлага, холбогдох мэдээллээр хангах ажлыг цахимжуулахад хамтарч Монголын төр, эрх зүй сэтгүүлийн 1995-2021 оны 95 дугаар, 6171 нүүр материалыг цахим хэлбэрт оруулсан. Мөн шүүхийн цахим системд зориулан эрүү, иргэн, захиргааны хэргийн хөдөлгөөний зураглалыг болон шүүхийн цахимжилттай холбоотойгоор цахимаар шийдвэрлэх боломжтой маргаан, цахимжуулснаар хэргийн хөдөлгөөний мэдээллийн уялдааг сайжруулах боломжийг практик судалгаанд үндэслэн боловсруулж, шүүхийн цахим системд хяналтын шатны шүүхийн шийдвэр байршуулах шалгуурыг (хувьсагч) тодорхойлсон байна.

Цахим системд зориулан бэлтгэсэн бүдүүвчийн жишээ.



“Шүүхийн практик судалгааны ажлын гүйцэтгэлийг үнэлэх аргачлал”-ыг боловсруулан батлуулж, уг баримт бичгүүдийн хүрээнд судалгааны ажлыг каталогжуулах ажиллагаа хийгдэж, тайлант хугацаанд хийгдсэн судалгаанууд, шаардлагатай мэдээллүүдийг цахимаар болон цаасаар төрөлжүүлэн хадгалж, сан үүсгэн тогтмол баяжуулж ажиллалаа.


Шүүхийн талаарх иргэд, оюутан, сурагчдын эрх зүйн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх зорилгоор “Шүүхийн боловсрол” хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын дээд шүүхийн цахим хуудсанд “Таны эрх зүйн боловсролд” цэсийг албан ёсоор ажиллуулж, тус цэсэд 9 анимейшн, 10 түгээмэл асуулт хариулт, 6 судалгааны тойм нийтлэл боловсруулж байршуулсан.

s&id=171&pr=170&tp=list&h=0

[НҮҮР ХУУДАС](#)
[МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХ](#)
[МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ](#)
[ТАЙЛАР, ЗӨВЛӨМЖ, ТОЙМ](#)
[ХЯНАЛТЫН ШАТНЫ ШҮҮХ ХУРАЛДААНЫ ТОГТООЛ](#)
[ШҮҮХ ХУРАЛДААНЫ ЗАР](#)
[ШҮҮХИЙН СУРГАЛТ, СУДАЛГАА, МЭДЭЭЛЛИЙН ХҮРЭЭЛЭН](#)
[ТАНЫ ЭРХ ЗҮЙН БОЛОВСРОЛД](#)

[Анимейшн, видео хичээл](#)
[Инфографик, зурагт хуудас](#)
[Түгээмэл асуулт, хариулт](#)
[Судалгаа, мэдээлэл](#)
[Шүүх хэвлэлийн хуудаснаа](#)

Таны эрх зүйн боловсролд: Монгол Улсын дээд шүүх ямар чиг үүрэг, бүтэцтэй ажилладаг вэ?



Watch on YouTube

Монгол Улсын дээд шүүхийн шүүгчийн манлайллыг дэмжих, шүүгчдийн нэр хүндийг улам өсгөх, олон нийтэд таниулах замаар шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг дээшлүүлэх” зорилгоор “Шүүгчийн манлайлал”-ын хөтөлбөрийг боловсруулж, хөтөлбөрийн хүрээнд шүүгчдийн мэдээллийг цуглуулж, Википедиа вебд байршуулах ажлыг эхлүүлээд байна. Мөн Шүүхийн боловсрол, Шүүгчийн манлайлал хөтөлбөрүүдийн хавсарсан ажлын хүрээнд Улсын дээд шүүхийн шүүгч, шүүх эрх мэдэлтэй холбоотой 13 сэдвийг википедиад байршуулсан.

Википедиад байршуулсан мэдээллийн жишээ.

→ → ↻ mn.wikipedia.org/wiki/Монгол_Улсын_Дээд_Шүүх

Chat New Tab

Бүртүүлэх Нэвтрэх ...

Монгол Улсын Дээд Шүүх
↕ 1 хэлээр ▾

Өгүүлэл
Хэлтэцүүлэг
Унших
Засварлах
Кодоор засварлах
Түүх
Хэрэглүүр ▾

1206 оны Улаан Бэрс жил их эзэн Чингис хаан "Их засаг" хуулийг нутарлан улнаар бичгийн их хүн Шихиуутагт улсын их заргаг цол хэргэм хүртээн, шүүх цаазны хэргийг эрхлүүлж байсан.

Түүх [засварлах | кодоор засварлах]

Эрт дээр үеэс Монгол Улсад **"Их засаг"**, **"Халх журам"** зэрэг олон арван хууль үйлчилж байсан бөгөөд тухайн үеийн шүүхийн үйл ажиллагааг тод харуулсан "Халх журам" хууль нь Улсын төв номын санд гар бичмэл эх хувьраа хадгалагдаж байна. Энэ хуулийн дагуу 1820-1913 он хүртэл буюу 93 жилийн турш шийдсэн хэргүүдийн түүвэр болох **"Улаан хацарт"** хэмээх бүтээл шүүхийн түүхэнд онцгой байр эзэлдэг.


Үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн ялсан 1911 оноос Богд хаант Монгол Улсад хууль цаазны 63 бичиг баримт батлагдсанаар бие даасан **Ариуган шүүн гэгсгээх газар** байгуулагджээ.

Ардын хувьсгалаас хойш

1921 онд Ардын хувьсгал ялснаар Монгол орны төр, нийгэм, эдийн засгийн бүтцэд үндсэн өөрчлөлт гарсан нь БНМАУ-д Ардын шүүх үүсэх эх сүүрэг тавигджээ. 1921 оны 3 дугаар сард **Дотоод яаманд "шүүн таслах хэлтэс"**, мөн оны 7 дугаар сард **Шүүх явдлын яам**, орон нутагт "зарга шийтгэх түр хэлтэс", Засгийн газрын дэргэд "түр цагийн шүүх" нь орчин цагийн шүүх бүрэлдэн тогтох анхдагч болжээ

Монгол Улсын Засгийн газрын гишүүдийн 1926 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн 15 дугаар, Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 21 дүгээр хурлаас **"Аливаа шүүн таслах газруудыг шинэчлэн байгуулах тухай дүрэм"**-ийг баталж 5 аймас, 3 хот, 71 хошуунд анхан шатны шүүхийг байгуулах тухай шийдвэр гарчээ.

Монгол Улсын Дээд Шүүх



Flage de l'Organisation

Статус идеалтай

Байгуулагдсан 1927 оны

www.supremecourt.mn

Хяналтын шатны шүүхээс хянан шийдвэрлэсэн тогтоолыг IBM SPSS программд шивж оруулах хувьсагчийн шалгуурыг багтаасан “Монгол улсын дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдааны шийдвэрийн судалгааны өгөгдлийн сангийн кодын ном”-ыг боловсруулж, уг шалгуурын дагуу эрүү, иргэн, захиргааны хяналтын шатны шүүхийн тогтоолыг шивж байршуулах ажлыг зохион байгуулж ажиллалаа.



УЛСЫН ДЭЭД ШҮҮХ
SUPREME COURT OF MONGOLIA

SPSS программд тогтоол оруулах кодын номын гарчгийн хэсэг.

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ХЯНАЛТЫН ШАТНЫ ИРГЭНИЙ ХЭРГИЙН ШҮҮХ ХУРАЛДААНЫ ШИЙДВЭРИЙН СУДАЛГААНЫ
ӨГӨГДЛИЙН САНГИЙН КОДНЫ НОМ

Code book of Supreme Court Data Base
Supreme Court of Mongolia, Civil Chamber

Улаанбаатар хот.
2023 он.

Агуулга

1. Хяналтын тогтоолын дугаар
2. Хэрэг хүлээн авсан огноо
3. Хяналтын тогтоолын огноо
4. Хяналтын шатны шүүхийн илтгэгч шүүгч
5. Анхан шатны шүүхийн нэрс
6. Анхан шатны шүүхийн шийдвэрийн он, дугаар
7. Давж заалдах шатны шүүхийн магадлалын он, дугаар
8. Нэхэмжлэгч нэр
9. Хариуцагч нэр
10. Гуравдагч этгээд нэр
11. Нэхэмжлэгч 1
12. Хариуцагч 1
13. Гуравдагч этгээд 1
14. Хяналтын шатны шүүхэд гомдол гаргагч 1
15. Хяналтын шатны шүүхэд гомдол гаргагч 2
16. Хэргийн ангилал
17. Нэхэмжлэлийн үнийн дүн
18. Маргааны төрөл
19. Маргааны төрөл 1
20. Маргааны төрөл 2
21. сөрөг нэхэмжлэл
22. маргааны төрөл 3
23. гуравдагч этгээд
24. маргааны төрөл 4
25. Хуулийн нэр
26. Хуулийн зүйл заалт

“Шүүхийн практик судлал 2023” хэлэлцүүлгийг зохион байгуулав. 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдөр бүх шатны шүүхийн Ерөнхий шүүгч, Тамгын газрын дарга нарыг оролцуулж уг хэлэлцүүлгийн зохион байгуулсан ба улсын хэмжээнд оролцоог бүрэн хангаж ажилласан.



“Шүүхийн практик судлал 2023” хэлэлцүүлгийн танхимаар оролцогчид.



Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх уралдааны шагнал гардуулах үеэр.

Хэлэлцүүлэгт хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, доктор М.Хатанзориг, УДШИХТанхимын шүүгч П.Золзаяа, Тамгын газрын дарга С.Заяадэлгэр, НБДШТГДарга Б.Мөнхбат нар илтгэл хэлэлцүүлж, оролцогчид санал хэлэх, асуулт асуух байдлаар зохион байгуулагдав. Хэлэлцүүлэгтэй хавсарган шүүхийн албан хаагчдын судалгааны ажлыг эрчимжүүлэх зорилгоор шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх уралдааныг амжилттай зохион байгуулж, шилдэг оролцогчдод шагнал гардуулсан.

4.4.ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ АЖИЛ

Шүүхийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд шүүн таслах болон бусад үйл ажиллагааны талаарх 253 мэдээ мэдээлэл, нийтлэл, ярилцлага, нэвтрүүлэг, видео, аудио контентыг давхардсан тоогоор 2056 хэвлэл мэдээллийн байгууллагаар олон нийтэд хүргэжээ.

Мэдээ, мэдээлэл

Хяналтын шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн нийгмийн анхаарал татсан хэрэг болон бусад үйл ажиллагааны талаар 188 мэдээллийг Улсын дээд шүүхийн цахим сайт болон 1659 хэвлэл мэдээллийг хэрэгслээр (давхардсан тоогоор) олон нийтэд хүргэж, сэтгүүлчдийн мэдээлэл авах хүсэлтийг тухай бүр хангалаа.

Тодруулбал, Нийт шүүгчийн хуралдаан, зөвлөгөөн, Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшигчтэй холбоотой-36, Намуудын өргөдөл, хариу-72, Хуулийн тайлбар-12, Олны анхаарал татсан хэрэг-27, Бусад-41 мэдээг олон нийтэд хүргэсэн байна.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ



2023.12.21
Шударга иргэдийн нэгдсэн эвсэл намын нэрийн өөрчлөлтийг бүртгүүлэх өргөдөл ирүүлжээ



2023.12.15
Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх Олон улсын эрүүгийн шүүхийн шүүгч Д.Эрдэнэбалсүрэнд баяр хүргэв



2023.12.14
Монгол үндэсний ардчилсан намын хаягийн өөрчлөлтийг бүртгэв



2023.12.20
Иргэний зориг ногоон намын дүрмийн өөрчлөлтийг бүртгүүлэх өргөдөл ирүүлэв



2023.12.14
Намын бүртгэлтэй холбоотой өргөдлүүд ирүүлжээ



2023.12.13
Б.Махбалыг хорих ялаас хугацааны өмнө суллаж, хяналт тогтоох үндэслэлтэй эсэхийг хянан хэлэлцэнэ

Шүүхийн шийдвэрийн тойм

Монгол Улсын шүүхийн тухай хуульд хэрэг хянан шийдвэрлэсэн шүүгч, шүүх бүрэлдэхүүн шүүхийн шийдвэрийг ойлгомжтой байдлаар, бичгээр тайлбарлахаар тусгасан. Энэ хүрээнд шүүгч гаргасан шийдвэрээ олон нийтэд ойлгомжтой байдлаар “Шүүхийн шийдвэрийн тойм” бичих нь 2021 оноос эхэлж, 2023 онд тогтмол ажил боллоо.

Улсын дээд шүүхийн шүүгчдийн бэлтгэсэн 20 тоймыг 295 хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэсэн бөгөөд тэдгээрийг www.supremecourt.mn сайтаас

17,313 удаа уншиж, 4,038 удаа хуваалцаж, сошиал хуудаст 2,965 удаа түгээсэн байна.

Аудио, видео контент, постер

Шүүн таслах үйл ажиллагааны мэдээлэл болон шүүгчдийн бэлтгэсэн шүүхийн шийдвэрийн тойм, бусад сэдвээр 27 видео, аудио мэдээлэл бэлтгэж олон нийтэд болон тусгай хэрэгцээт иргэдэд зориулж түгээлээ. Мөн supremecourt.mn сайтад аудио, видео мэдээллийн цэсийг бий болгосон байна.

Тухайлбал, МҮОНР-ийн “Соёмбо” нэвтрүүлгээр шүүхийн шийдвэрийн 16 тоймыг олон нийтэд хүргэж, www.supremecourt.mn сайтад аудио хэлбэрээр байршууллаа.

Мөн Шүүхийн мэдээллийг тусгай хэрэгцээт иргэдэд хүртээмжтэй хүргэх зорилгоор Д.Нацагдоржийн нэрэмжит номын сантай хамтран ажиллаж, шүүхийн шийдвэрийн 16 тоймын аудио хувилбарыг уншлагын танхимаар олон нийтэд хүргэж байна.

Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн Д.Мөнхтуяа, шүүгч Б.Батцэрэн нар “Ярьж буй хууль” нэвтрүүлэгт тус тус оролцсоныг цахим сайт, пэйж хуудаснаас үзэх боломжтой байршуулав.



2023.11.29 15:56

Улс төрийн намын бүртгэлтэй холбоотой асуултад шүүгч хариулж байна



2023.06.30 20:09

Ш.Батхүү нарт холбогдох хэргийг хянан хэлэлцэв

Шинэ контентуудын санаачилгын хүрээнд “Шүүгч хариулж байна” нэвтрүүлэг бэлтгэж эхэллээ. Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн Д.Мөнхтуяа улс төрийн намын бүртгэлтэй холбоотой олны анхаарал татсан асуултад хариулж, тус нэвтрүүлгийн анхны дугаарт оролцсоныг сайт, пэйжээр олон нийтэд хүргэв.

Олны анхаарал татсан хэргийн шүүх хуралдааны шийдвэр уншиж сонсгох хэсгийн бичлэг хийж, олон нийтэд түгээх ажлыг эхлүүлэв. Улсын дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар хянан хэлэлцсэн Ш.Батхүү нарт холбогдох хэргийн шүүх хуралдааны шийдвэр унших хэсгийн бичлэгийг supremecourt.mn сайт болон Монгол Улсын дээд шүүх хуудсаар олон нийтэд хүргэсэн.

Постер

Улсын дээд шүүхийн шийдвэр, үйл ажиллагааны мэдээллийг олон нийтэд товч, хялбар аргаар хүргэх үүдгээс постер бэлтгэж, нийгмийн сүлжээгээр олон нийтэд хүргэж байна. Хууль зөв хэрэглэх талаар гаргасан албан ёсны тайлбараар 14 багц, хуулийн зохицуулалтаар 3 постер бэлтгэж, “Монгол Улсын дээд шүүх” хуудсаар олон нийтэд хүргэсэн байна. Постеруудыг Улсын дээд шүүх пэйж хуудсаас 410,371 удаа үзэж 2118 удаа хуваалцжээ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөв хэрэглэх албан ёсны тайлбартай танилцана уу.

https://www.supremecourt.mn/files/20239/0_1696581653.pdf



Boost this post to reach up to 2615 more people if you spend \$14.

Boost post

Пүрэв, Оюунжаргал, Miigaa Sh and 56 others

2 comments 236 shares

Нийтлэл, ярилцлага

Цаг үеийн үйл явдалтай холбоотойгоор 18 ярилцлага, нийтлэлийг давхардсан тоогоор 32 хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэсэн байна.

“Нийт шүүгчийн II чуулган”

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д бүх шатны шүүхийн нийт шүүгчээс бүрдсэн Нийт шүүгчийн чуулганыг хоёр жил тутам зохион байгуулахаар заасны дагуу ээлжит хоёрдугаар чуулган 2023 оны 9 дүгээр сарын 28-29-ний өдөр хуралдсан. “Нийт шүүгчийн II чуулган”-ы ил тод нээлтэй байдлыг хангах ажлыг зохион байгуулж, 5 мэдээг 41 хэвлэл мэдээллийн байгууллага, “Эрүүгийн хэргийн шүүгчдийн зөвлөгөөн”-ий талаарх 2 мэдээг 20 хэвлэл мэдээллийн байгууллагаар олон нийтэд хүргэсэн. Мөн чуулганыг 11 хэвлэл мэдээллийн байгууллага сурвалжилж, бүх шатны шүүхийн 19 шүүгчээс цаг үеийн болон бусад сэдвээр ярилцлага авчээ. Эрх зүйн хөтөч” нэвтрүүлгийн дугаарыг “Нийт шүүгчийн II” чуулганы хүрээнд бэлтгэж үнэ төлбөргүйгээр МҮОНТ-ээр олон нийтэд хүргэсэн.



Сурагчид Улсын дээд шүүхэд:

Шүүхийн ил тод, нээлттэй байдлыг хангах, сурагчдын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, мэргэжил сонголтод дэмжлэг үзүүлэх зорилгоор Улсын дээд шүүхийн чиг үүрэг, үйл ажиллагаатай сурагчдыг танилцуулах хөтөлбөрийг 2023 онд эхлүүллээ. Ерөнхий боловсролын “Шинэ эхлэл” сургуулийн 22 сурагч 2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр Улсын дээд шүүхэд зочилж, шүүгч, ажилтнууд ажлаа танилцуулан холбогдох асуултад хариулав.



4.5. ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА

Шүүхийн гадаад харилцаа жилээс жилд өргөжин тэлж шүүгч, ажилтнууд тив дэлхийн болон олон улсын бүсийн чуулга уулзалт, эрдэм шинжилгээний бага хуралд оролцож шүүн таслах ажиллагааны талаарх туршлага судлах ажил өргөжсөөр байна. Цар тахлын нөлөөгөөр завсарлаад байсан олон уулзалт, арга хэмжээ биетээр зохион байгуулагдах боломж бүрдэж, гадаад арга хэмжээ идэвхжилээ. Тухайлбал:

МУДШ-ийн шүүгч, албан хаагчид Нидерландын Хаант Улсын Гааг хотод зохион байгуулагдсан Олон Улсын Эрүүгийн Шүүхийн “Шүүхийн жилийн нээлт” арга хэмжээ, БНСУ-ын Шүүхийн сургалт, судалгааны хүрээлэнгийн урилгаар 2023 оны 4 дүгээр сарын 24-28-ны өдрүүдэд тус улсын Сөүл хотноо “БНСУ-ын шүүхийн цахимжилт” сэдэвт сургалт, айлчлал, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн практик хэрэглээ, түүний нэгдмэл байдлыг хангах арга механизм, хууль тайлбарлан хэрэглэх практик, түүгд ХБНГУ-ын дагнасан хэвлэлийн байгууллагуудын үүрэг оролцоо, шүүхийн цахимжуулалтын бодлого, улс төрийн намын бүртгэл сэдэвт туршлага солилцох айлчлал, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Лакнау хотноо зохион байгуулагдсан “Дэлхийн Ерөнхий шүүгч нарын 24 дэх удаагийн чуулга уулзалт”, Бүгд Найрамдах Солонгос Улсын Сөүл хотод болсон “Олон улсын эрүүгийн шүүх ба Ази-Номхон далай: Ромын дүрмийн өнгөрсөн, одоо, ирээдүй – бүс нутгийн нэгдмэл байдлын төлөөх алсын хараа” сэдэвт өндөр түвшний зөвлөгөөн, Бүгд Найрамдах Турк Улс, Швейцарын Холбооны Улсад албан айлчлал, Олон улсын эрүүгийн шүүхээс Америкийн Нэгдсэн Улсын Нью-Йорк хотод зохион байгуулсан Ромын дүрмийн Оролцогч улсуудын холбооны 22 дахь удаагийн хурал,

Сингапур улсын Сингапурын шүүхийн коллежид туршлага судлах айлчлалд тус тус оролцсон байна.

Гадаад хамтын ажиллагааны хүрээнд зохиогдсон уулзалтууд:
- Тамгын газрын дарга С.Заяадэлгэр 2023 оны 1 дүгээр сарын 9-ны өдөр Европын Холбооноос Монгол Улсад суугаа Төлөөлөгчийн газраас зохион байгуулсан ажил хэргийн уулзалтад оролцож, хамтын ажиллагааны асуудлаар;
- Шүүгч Ц.Цогт Европын Холбооноос Монгол Улсад суугаа Төлөөлөгчийн газрын Хамтын ажиллагааны хэлтсийн дарга Адриен Мүрг, ажилтан Евгения Фараза нартай 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр хамтын ажиллагааны асуудлаар;
- Ерөнхий шүүгч Д.Ганзориг, Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн Ч.Хосбаяр нар БНКУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд Габит Койшибаев, зөвлөх Сабит Негметжанов нарыг 2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр хамтын ажиллагааны асуудлаар;
- Ерөнхий шүүгч Д.Ганзориг, Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн Ч.Хосбаяр нар Бүгд Найрамдах Киргизстан Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч Базербек Замирбек, Тамгын газрын дарга Мамыров Эркинбек Тобокелович, Ерөнхий шүүгчийн орлогч Мусаев Нурлан Алишерович нартай 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдөр цахимаар хамтын ажиллагааны асуудлаар;
- Шүүгч Ц.Цогт, Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирал Д.Эрдэнэчимэг нар АНУ-ын Үндэсний шүүхүүдийн төвийн захирал Дэвид Сакар тэргүүтэй төлөөлөгчдийг 2023 оны 5 дугаар сарын 19-ны өдөр хүлээн авч, хамтын ажиллагааны талаар;
- Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн Ч.Хосбаяр 2023 оны 2 дугаар сарын 03-ны өдөр Канад Улсын Нью Брансвик мужийн Давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч Марк Ричард тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч, хамтын ажиллагааны талаар;
- Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн Ч.Хосбаяр, Иргэний хэргийн танхимын тэргүүн Г.Алтанчимэг, Захиргааны хэргийн танхимын тэргүүн Д.Мөнхтуяа нар Европын Холбооны Техникийн туслалцаа, мэдээлэл солилцох хөтөлбөрийн хүрээнд ажилласан Итали Улсын шүүгч Мариа Жулиана Сивинини, Австри Улсын шүүгч Гернот Пош тэргүүтэй төлөөлөгчдийг 2023 оны 3 дугаар сарын 29-ний өдөр хүлээн авч, хамтын ажиллагааны талаар;
- Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн Ч.Хосбаяр, Иргэний хэргийн танхимын тэргүүн Г.Алтанчимэг, Захиргааны хэргийн танхимын тэргүүн Д.Мөнхтуяа нар Европын Холбооны Техникийн туслалцаа, мэдээлэл солилцох хөтөлбөрийн хүрээнд ажилласан Итали Улсын шүүгч Мариа Жулиана Сивинини, Австри Улсын шүүгч Гернот Пош тэргүүтэй төлөөлөгчдийг 2023 оны 3 дугаар сарын 29-ний өдөр хүлээн авч, хамтын ажиллагааны талаар;
- Ерөнхий шүүгч Д.Ганзориг, Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн Ч.Хосбаяр нар Бүгд Найрамдах Казакстан Улсаас Монгол Улсад суугаа элчин сайд Габит Койшибаевыг 2023 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр хүлээн авч уулзаж, хамтын ажиллагааны талаар;
- Ерөнхий шүүгч Д.Ганзориг, Иргэний хэргийн танхимын тэргүүн Г.Алтанчимэг нар Бүгд Найрамдах Солонгос Улсаас Монгол Улсад суугаа элчин сайд Ким Жун Гүгийг 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдөр хүлээн авч уулзаж, хамтын ажиллагааны талаар;
- Ерөнхий шүүгч Д.Ганзориг, Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн Ч.Хосбаяр, Захиргааны хэргийн танхимын тэргүүн Д.Мөнхтуяа нар Ханнс-Зайделийн сангийн Ерөнхий нарийн бичгийн дарга Оливер Иёрг болон түүний төлөөлөгчдийг 2023 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр хүлээн авч уулзаж, хамтын ажиллагааны талаар;
- Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн Ч.Хосбаяр Бүгд Найрамдах Турк Улсын Хууль зүйн дэд сайд Хасан Илмаз болон түүний төлөөлөгчдийг 2023 оны 10 дугаар сарын 5-ны өдөр хүлээн авч уулзаж, хамтын ажиллагааны талаар;
- Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Д.Ганзориг, шүүгч Б.Батцэрэн, Ц.Цогт нар Шүүгч, хуульчдын хараат бус байдлын асуудал хариуцсан Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын тусгай илтгэгч Маргарет Саттертуэйт тэргүүтэй төлөөлөгчдийг 2023 оны 11 дүгээр сарын 9-ний өдөр хүлээн авч уулзлаа.

- Захиргааны хэргийн танхимын тэргүүн Д.Мөнхтуяа Европын Аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Ардчилсан институт хүний эрхийн албаны дарга Маттео Меккаччи болон түүний төлөөлөгчдийг 2023 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр хүлээн авч уулзаж, хамтын ажиллагааны талаар;

- Шүүгч Ц.Цогт Бангкок дахь Европын Холбооны Төлөөлөгчийн газрын Хамтын ажиллагааны хэлтсийн дарга Даниел Хачез болон Улаанбаатар дахь Европын Холбооны Төлөөлөгчийн газрын Хамтын ажиллагааны хэлтсийн хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн Апприоу Арно Пиерре нарыг 2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр хүлээн авч хамтын ажиллагааны асуудлаар тус тус уулзалт хийсэн байна.

Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чиглэлээр:

Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн Дэлхийн оюуны өмчийн байгууллагын Шүүхийн хүрээлэн, Монгол Улсаас Швейцарын Холбооны Улсад суугаа Байнгын төлөөлөгчийн газар, Сингапур Улсын Дээд шүүхийн Гадаад харилцааны газар, Гадаад харилцааны яамны Олон талт хамтын ажиллагааны газар, ДОӨБ-ын Шүүхийн хүрээлэнтэй цахим уулзалт хийж, хамтын ажиллагааны асуудлаар тус тус уулзалт хийхэд дэмжлэг үзүүлэн ажилласан байна.

Шүүхийн даалгаврын хүрээнд:

Жилийн эцсийн тайлант хугацаанд шүүхийн даалгавартай холбоотой 73 албан бичгийг холбогдох байгууллагууд руу хугацаа алдалгүй хүргүүлж ажилласан. Үүнд: Монгол Улсын дээд шүүхээс гадаад улсад нийт 24 шүүхийн даалгавар илгээсэн байна. Хилийн чанадаас нийт 14 шүүхийн даалгавар тус тус ирснийг харьяалах шүүхэд хүргүүлэн гүйцэтгүүлэх арга хэмжээг авсан. Мөн Хилийн чанадад гүйцэтгүүлэхээр хүргүүлсэн, ажиллагаа нь хийгдэж буй даалгавруудын талаарх нийт 15 лавлагааг илгээсэн ба хэлбэрийн шаардлага хангаагүй 3 шүүхийн даалгаврыг буцааж хүргүүлсэн ба шүүхийн даалгавартай холбоотой нийт 4 хариу албан бичгийг тус тус илгээсэн байна.

Гадаад харилцаа хамтын ажиллагааны албаны бусад чиг үүргийн хүрээнд:

Гадаад харилцааны асуудлаар хийх уулзалт, зөвлөгөөний бэлтгэлийг урьдчилан хангаж, удирдлагыг тухайн асуудлаарх шаардлагатай мэдээллээр ханган Ерөнхий шүүгч болон шүүгч нарын 8 гадаад айлчлалд давхардсан тоогоор 28 шүүгч, албан хаагчийг оролцуулж, 13 уулзалт, 1 гадаад сургалтыг зохион байгууллаа.

Гадаад улс орны шүүхийн үйл ажиллагааны туршлага судалж, манай улс оронд нэвтрүүлж болох зүйлийг хэрэгжүүлэх талаар анхаарал хандуулан ажиллаж байна.

4.6. САНХҮҮ, НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулиар баталсан төсвийг Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлэн зориулалтын дагуу зарцуулж ажиллав.

Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу УДШ-ийн 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу нээлттэй тендер 4, онцгой журмаар 4, нийт 8 тендер зарлаж амжилттай хэрэгжүүлсэн бөгөөд 2024 оны худалдан авах төлөвлөгөөг боловсруулж батлуулсан.

НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ



АУДИТ

2021, 2022 онд “Зөрчилгүй” дүгнэлт авсан.



ЗУРАГ, ТӨСӨВ

Нийслэлийн Хангарди ордоныг шүүхийн шаардлагад нийцүүлэх Их засварын ажлын зураг төсвийг боловсруулж батлуулсан.



ГАЗРЫН БҮРТГЭЛ

3 дүүргийн газрын бүртгэлийн гэрчилгээг цахимжуулсан.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаж 2023 онд нийт 159 мэдээлэл оруулсан.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу санхүүгийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулан ажилласан.


Төрийн өмчийн хөдлөл өөрчлөлийн бүртгэлийг ТӨХ-ны хөрөнгийн цахим бүртгэлийн системд 2022 оны жилийн эцсийн тайлан болон хөрөнгийн хөдлөлт, өөрчлөлт иж бүрэн нэгтгэж тайлагнасан.

Төсвийн шууд захирагчийн 2024 оны санхүүгийн тайланг гарган төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэв.

4.7. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллах чиг үүргийн хүрээнд:





Эрүү, иргэн, захиргааны хэргийн хөдөлгөөний удирдлагын хэрэгжилтэд 2023.03.27-2023.04.27-ны өдрийг хүртэлх хугацаанд хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг дараах чиглэлийн хүрээнд хийж гүйцэтгэлээ.

- Шүүхийн шийдвэрийг цахим хуудаст байршуулах болон тавигдах техникийн шаардлага хангасан эсэх;
- Шүүх хуралдааны дууны, дуу-дүрсний бичлэг хийх, архивлах, хадгалах ажлыг зохион байгуулж байгаа эсэх;
- Шүүх хуралдааны явцыг мэдээлэх цахим системийг ашиглаж байгаа эсэх;
- Эрүү, иргэн, захиргааны хэргийн хөдөлгөөний нийтлэг аргачлал болон шүүхэд албан хэрэг хөтлөх журмын хэрэгжилтийн хүрээнд холбогдох баримт бичиг, эрх зүйн актуудыг программд оруулсан эсэхийг шалгаж, хариуцсан ажилтнуудтай уулзан, арга зүйн туслалцаа үзүүлж, санал зөвлөмж өгч ажиллалаа.

Тамгын газрын 2023 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн тайланд явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг Тамгын газрын нийт хэлтэс, албадын дарга нартай хийсэн зөвлөлдөх уулзалтад танилцууллаа.

Явцын хяналт-шинжилгээний ажлын хүрээнд гарсан зөвлөмжид гүйцэтгэлийн төлөвлөлтийг сайжруулах, төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллахад анхаарах, тайлагналтыг хэрхэн сайжруулах талаар тусгасан болно.

Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын даргын 2022 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн А/04 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр", 2 дугаар хавсралтаар батлагдсан "Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр", "Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын шинэ ажилтны дасан зохицох дэд хөтөлбөр"-ийн биелэлтэд эхний хагас жилийн явцын хяналт-шинжилгээг хийж, Тамгын газрын нийт хэлтэс, албадын дарга нартай хийсэн зөвлөлдөх уулзалтад танилцуулав. Уулзалтын үеэр хөтөлбөрүүдийн биелэлтийг ханган ажиллах, хэлтэс, албад хоорондын ажлын уялдаа холбоогоо сайжруулах, ажлын үр нөлөөг дээшлүүлэх, үр дүнг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай талаарх зөвлөмжийг танилцуулсан.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв. Хуульд тухайлан заасан мэдээллийг байнга ил тод нээлттэй байлгах, тухайн мэдээллүүдийг тогтмол шинэчлэх, баяжилтыг тухай бүр хуульд заасан хугацаанд хийх шаардлагатай талаар санал, зөвлөмж гаргасан.

Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын бүтцийн нэгжүүдийн албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж гарсан санал, зөвлөмжийг холбогдох талуудад танилцуулав.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажилд холбогдох эрх зүйн орчин бүрдүүлэх чиг үүргийн хүрээнд:

“Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт зохион байгуулах журам”-ыг боловсруулж, Тамгын газрын даргын 2023 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн А/47 дугаар тушаалаар батлуулан ажиллаж байна.

Байгууллагын эрсдэлийн үнэлгээ хийх журмыг Дотоод аудитын албатай хамтран боловсруулж, Тамгын газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн А/102 дугаар тушаалаар батлуулсан. Тамгын газрын холбогдох нэгжийн удирдлага, албан хаагчдыг түүврийн аргаар сонгон авч, эрсдэлийн үнэлгээ хийх зорилго бүхий хяналтын хуудсыг цахим хэлбэр (google forms)-ээр боловсруулан, 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдөр асуумжийг авч, эрсдэлийн үнэлгээний тайлан гаргаж танилцуулсан.

4.8.ДОТООД АУДИТ

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар

Эрсдэлд суурилсан 2023 оны дотоод аудитын жилийн төлөвлөгөөг боловсруулан 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 12 тоот Ерөнхий шүүгчийн захирамжаар батлуулан, төлөвлөгөөний дагуу удирдамж гарган аудит хийж, мөн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүний нөөцийн үйл ажиллагаа, “Шүүхийн хүний нөөцийн программ ашиглах журам”-ын хэрэгжилтэд аудит хийж, тайлан зөвлөмж гарган холбогдох талуудад танилцуулсан.

Эрсдэлийн түвшин тогтоох, үнэлгээ хийх аргачлалыг боловсруулж, Улсын Дээд шүүхийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, хөдөлмөрийн харилцааны эрсдэл тооцох аргачлалыг боловсруулж батлуулсан байна.

Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн үйл ажиллагаанд батлагдсан төлөвлөгөөний дагуу 2023 оны 10 дугаар сард аудит хийж аудиттай холбогдуулан дүгнэлт, зөвлөмж гарган холбогдох хэлтэст танилцуулсан байна.

Төсөв, санхүүгийн хяналт, шалгалтын талаар

Шилэн дансны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор уг хуулийн 8 дугаар зүйлийн 2-т заасны дагуу дотоод хяналтыг зохион байгуулж 2021 оны батлагдсан төсөв, 1-дүгээр улирлын төсвийн гүйцэтгэл, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ зэргийг шилэн дансанд байршуулж жигдрүүлснээр <http://shilendans.gov.mn/> сайтад мэдээлэл хуулийн хугацаанд тогтмол тавигдаж хэвшсэн.

-----o0o-----